



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Нийцлийн аудитын тайлан

**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТЭД ХУУЛЬ
ЖУРМЫН ДАГУУ ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

**2020 оны 09-11 дүгээр
сар**



**АУДИТЫН СЭДЭВ: Орон нутгийн хөгжлийн
сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт**

Товчилсон үгийн тайлбар.....	4
Хүснэгтийн товъёог.....	5
Хавсралтын	
товъёог.....	6
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл....	7-8
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	9
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.....	9
1.2. Аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.....	9
1.2.1 Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг холбогдох журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөсөн байна.	9-11
1.2.2. Аймаг, сумдын ОНХС-ийн нийт эх үүсвэрийн 95.4 хувийг ОНХНС-гийн орлогын шилжүүлгээр бүрдүүлсэн байна.....	12
1.2.3. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХСанд олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль журмыг баримталж хуваарилсан байна.....	12-14
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭГ ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.....	15
2.1. Аймгийн дүнгээр 2019 онд иргэдийн саналаар дэмжигдээгүй 2476.9 сая төгрөгийн 135 төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.....	155
2.1.1. Ихэнх сумууд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу төлөвлөөгүй байна.....	15-16
2.1.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээ орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан боловч холбогдох журам, зааврын дагуу төлөвлөгдөөгүй байна.....	16-19
2.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллаагүй байна.....	19
2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.	19-27
2.2.2. Аймаг, сумын ОНХС-гаас нийтдээ 131.4 сая төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.....	28-30
2.2.3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж ашиглалтад оруулсан нийт 1285.9 сая төгрөгийн хөрөнгийг орлогод аваагүй, орон нутгийн өмчид бүртгээгүй байна.....	30-31
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЖ, ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.....	32
3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.....	32

2	
3.1.1.	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, Иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллаагүй байна.....32-33
3.1.2.	Аймаг, сумын захиргааны байгууллагууд ОНХС-ийн хэрэгжилт, үр дүнд хийх хяналт, шинжилгээ үнэлгээг холбогдох журмын дагуу хийж гүйцэтгээгүй байна.....33
3	
3.2.	ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар журмын дагуу тайлагнаж, хүргүүлж ажилласан байна.....34
3.2.1.	ОНХСангийн төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийн тайланг Төсвийн тухай хууль болон журам, зааварт тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлж ажилласан байна.....34
3.2.2	Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлсэн боловч тайлант онд алдаа, зөрчлийг давтан гаргасан байна.....34-36
3.2.3.	Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа нь орон нутгийн хөгжлийг дэмжихэд зохих үр дүнгээ өгч байгаа боловч орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим хууль журамд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.....36-38
	Санал асуулгын талаар.....39-40
	Холбогдох байгууллагын санал:.....41-42
	ДҮГНЭЛТ:.....43-44
	ЗӨВЛӨМЖ:.....45-46
	ХАВСРАЛТУУД:.....47-54

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УИХ	Улсын Их Хурал
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ИНХ	Иргэдийн Нийтийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс

Хүснэгт, графикийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ОНХС- аймгийн ОНХС-нд хуваарилахаар батлагдсан орлогын шилжүүлэг	9
Хүснэгт 2	Тогтвортой амьжиргаа-3 төслөөс сумуудад олгох урамшуулал, дэмжлэг	9
Хүснэгт 3	Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан аймаг, сумын ОНХС-ийн төсөв	10
Хүснэгт 4	Аймаг, сумын ОНХС-ийн тодотгосон төсөв	11
Хүснэгт 5	Аймаг, сумын ОНХС-ийн хуваарилалтыг өмнөх онтой харьцуулсан судалгаа	14
Хүснэгт 6	Аймаг, сумуудын ОНХС-ийн орлогын шилжүүлгийн 2019 оны хуваарилалт	14
Хүснэгт 7	Алдаа зөрчлийн харьцуулалт	35
График №1	2017-2019 оны алдаа зөрчлийн харьцуулалт	35

Хавсралтын товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Баян-Өлгий аймгийн ОНХС-ийн 2019 оны эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт	47
Хавсралт 2	Баян-Өлгий аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хийгдсэн ажлын сонгон шалгаруулалт	48
Хавсралт 3	Баян-Өлгий аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	49
Хавсралт 4	Баян-Өлгий аймгийн ОНХС-ийн 2019 оны хөрөнгийн зарцуулалтад аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт	50
Хавсралт 5	Өмнөх оны ОНХС-ийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	51
Хавсралт 6	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн чиг үүргүүд	52
Хавсралт 7	Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн чиг үүргүүд	53
Хавсралт 8	Баян-Өлгий аймгийн 2019 онд ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар иргэдээс авсан санал, асуулга	54
Хавсралт 9	Санал асуулгын нэгтгэл	55

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/100 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэнэ.
Аудитын зорилт	Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг УИХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн.Үүнд: • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх • Орон нутгийн өхгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг журмын дагуу төлөвлөж, зарцуулсан эсэх • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2019 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналыг аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСТ, ХОХБТХэлтэс, баг, хороодын Засаг дарга, ИНХ-ыг хамруулан шалгалаа.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн аудит. Тулгуур зарчим MNS6817-6:20208 МУЕА-ын 2016 оны А/146 тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримталж аймаг, сумын ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн болон холбогдох хэлтсийн албан тушаалтантай ярилцах, иргэдээс санал асуулга авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөөг тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Назгүл, аудитор Х.Еркебулан, У.Ербол нар хамтран гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөг УАГ-аас 2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр хүлээн авч талбарын ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан 2020 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн дотор тушаалаар баталгаажуулж, 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор УАГ-ын Нийцлийн аудитын газарт хүргүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээ.

Хүндрэл бэрхшээл

.....

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитад Баян-Өлгий аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, 13 сум, 1 тосгоны Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны үйл ажиллагааг бүрэн хамрууллаа.

Аудитаар аймаг болон 12 сум, 1 тосгоны 2019 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг газар дээр нь үзэж шалган, 665 иргэнээс санал асуулга авч дүнг нэгтгэн тайланд тусгав.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.

1.2. Аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.

1.2.1 Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг холбогдох журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөсөн байна.

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулиар Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 7281.9 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна. Үүнээс 365.6 сая төгрөг нь суурь зарлагын санхүүжилт байна.

Хүснэгт №1	сая төгрөгөөр
Санхүүжилтийн эх үүсвэр	Шилжүүлгийн хэмжээ
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг	7,281.90
Үүнээс: Урсгал зардал санхүүжүүлэх	365.60

Эх сурвалж: Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулийн 4 дүгээр хавсралтаар олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр буюу Тогтвортой амьжиргаа-3 төслийн санхүүжилтээс 2019 онд сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал, дэмжлэгийг сум тус бүрээр дараах байдлаар төлөвлөж баталсан байна.

Хүснэгт №2	сая төгрөгөөр		
Аймаг, сум	Дэмжлэг	Урамшуулал	Нийт
Алтай	41.1	31.5	72.6
Алтанцөгц	20.1		20.1
Баяннуур	41.6		41.6
Бугат	20.3		20.3
Булган	85.9		85.9
Буянт	23.0		23.0
Дэлүүн	83.7	63.3	147.0
Өлгий	96.8		96.8
Ногооннуур	73.4		73.4
Сагсай	33.7		33.7
Толбо	35.0		35.0
Улаанхус	63.5		63.5
Цэнгэл	78.3		78.3
Дүн	696.4	94.8	791.2

Эх сурвалж: Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

Сангийн яамнаас “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.2-т заасны дагуу тус аймагт олгох ОНХС-ийн орлогын шилжүүлэгт үндэслэн сумдын ОНХС-ийн суурь тооцооллыг гаргаж, аймгийн Засаг даргад ирүүлсэн байна.

Аймгийн Засаг дарга сумдын ОНХС-д хуваарилах орлогын шилжүүлгийн дүнг тооцохдоо Сангийн яамны ирүүлсэн суурь тооцооллын дүн, ОНХС-аас санхүүжих суурь зардал болон Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.4, 60.2.5-д заасан бусад эх үүсвэрийн хамт, ОНХС-аас хуваарилсан хөрөнгөөс аймгийн ОНХС-д үлдэх хөрөнгийг аймгийн төсвийн төсөлд журамд заасан хавсралт маягтын дагуу тусгаж, аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрийг тухайн шатны ИТХ хэлэлцэн батална гэсэн боловч аймгийн ИТХ-ын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө, оруулалт, төсөл, арга хэмжээ нэг бүрээр хэлэлцэж батлаагүй, хурлын тэмдэглэл, нотлох баримт байхгүй байна.

Аймгийн ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө, оруулалт, төсөл, арга хэмжээ батлахдаа Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.7-д заасныг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн VIII дугаар ээлжит хуралдааны 51 дүгээр тогтоолын хавсралтаар аймаг, сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг дараах байдлаар хуваарилсан байна.

Хүснэгт №3

сая төгрөгөөр

№	Аймаг, сум	Хот тохижуулах газрын урсгал зардлын 50 хувь	Малын вакцинжуулалтын зардал	ОНХС-аас олгох урсгал зардлын дүн	Олон Улсын төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал	Олон Улсын төсөл хөтөлбөрөөс олгох дэмжлэгийн хуваарилалт	АМХБАТЗ-ийн төлбөрийн 50 хувь	Хүн амын нягтрал, алслалт, нутаг, дэвсгэрийн хэмжээнээс хамааруулан олгох дүн	Сумын ОНХС-ийн дүн	Нийт хуваарилагдах дүн
1	Алтай		27.0	27.0	31.5	41.1		105.5	178.1	205.1
2	Алтанцэгц		18.1	18.1	-	20.1	19.0	51.6	90.7	108.9
3	Баяннуур		27.1	27.1	-	41.6	13.8	106.7	162.0	189.1
4	Бугат		17.5	17.5	-	20.4	0.9	52.2	73.5	91.0
5	Булган		26.6	26.6	-	85.9	11.9	220.4	318.2	344.8
6	Буянт		19.5	19.5	-	23.0	13.1	58.9	95.0	114.4
7	Дэлүүн		35.7	35.7	63.4	83.8	9.8	214.9	371.7	407.4
8	Ногооннуур		25.3	25.3	-	73.4	44.8	106.9	225.0	250.3
9	Сагсай		24.4	24.4	-	33.7	16.1	86.6	136.6	161.0
10	Толбо		28.2	28.2	-	35.0	2.9	89.8	127.7	155.9
11	Улаанхус		34.6	34.6	-	63.5	7.5	162.8	233.7	268.3
12	Цэнгэл		39.8	39.8	-	78.3	29.6	200.8	308.7	348.5
13	Цагааннуур		3.2	3.2	-	0.0		81.3	81.3	84.5
14	Ёлгий	21.5	5.6	27.1	-	96.8	0.4	248.2	345.4	372.5
15	Аймгийн ОНХС		11.7	11.7	-		4,168.7	0	4168.7	4,180.4
	НИЙТ ДҮН	21.5	344.1	365.6	94.8	696.4	4,338.4	1786.6	6,916.3	7,281.9

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2018 оны 51 дүгээр тогтоолын хавсралт

ОНХНС-аас аймагт олгох орлогын шилжүүлгээс суурь зарлагыг хасаж тооцоход аймаг, сумдын ОНХС-д 6916.3 сая төгрөг олгохоор төлөвлөжээ.

Аймгийн орон нутгийн төсвийн татварын орлого 2018 онд 479.0 сая төгрөгөөр, сумдын орон нутгийн төсвийн татварын орлого 757.6 сая төгрөгөөр нийтдээ 1236.6 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна. Үүнээс Дэлүүн сум ОНХСанд хөрөнгө хуваарилсан бөгөөд бусад сум болон аймгийн төсвийн давсан орлогоос ОНХСанд хөрөнгө хуваарилаагүй байна.

Аймгийн ОНХС-ийн төлөвлөгөөг ИТХ-ын 2019 оны ээлжит IX дүгээр хуралдааны 66 дугаар тогтоолоор ОНХС-ийн 2018 оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр 87.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгон баталсан байна.

Алтай, Булган, Буянт, Дэлүүн, Өлгий сум болон Цагааннуур тосгоны ОНХС-ийн төлөвлөгөөг сумын ИТХ-ын тогтоолоор урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр нийт 190.8 сая төгрөгөөр, Дэлүүн сумын ОНХС-ийн төлөвлөгөөг татварын хэмжээг нэмэгдүүлсэн баталсан дүнгээс 45.0 сая төгрөгөөр буюу нийт 278.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгон баталсан байна.

Хүснэгт №4

сая төгрөгөөр

Аймаг, сумын ОНХС	Аймгийн ИТХ-аас баталсан дүн	Аймаг, сумын ИТХ-аас тодотголоор баталсан		Батлагдсан төлөвлөгөө
		Урьд оны үлдэгдлээс	2019 оны татварын орлогыг нэмэгдүүлж баталсан дүнгээс хуваарилсан	
Алтай	178.1	15.5		193.60
Алтанцөгц	90.7			90.72
Баяннуур	162.0			162.00
Бугат	73.5			73.47
Булган	318.2	24.2		342.40
Буянт	94.9	29.3		124.20
Дэлүүн	371.7	55.0	45.0	471.70
Ногооннуур	225.0			225.00
Сагсай	136.4			136.44
Толбо	127.7			127.74
Улаанхус	233.8			233.80
Цэнгэл	308.7			308.67
Өлгий	345.4	65.0		410.42
Цагааннуур	81.3	1.8		83.10
Аймгийн ОНХС	4,168.7	87.2		4,255.90
Дүн	6,916.2	278.0	45.0	7,239.2

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, ОНХС-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

1.2.2. Аймаг, сумдын ОНХС-ийн нийт эх үүсвэрийн 95.4 хувийг ОНХНС-гийн орлогын шилжүүлгээр бүрдүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус аймгийн ОНХС-д 2019 онд нийтдээ 6916.2 сая төгрөгийн орлогын шилжүүлэг олгохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 79.3 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу олгосон байна.

Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сан тайлант онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 6836.9 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хүлээн авч, аймаг, сумын ИТХ-аас баталсан урьд оны үлдэгдлээс санхүүжих 278.0 сая төгрөг болон 2019 оны татварын орлогыг нэмэгдүүлж баталсан дүнгээс санхүүжих 45.0 сая төгрөг, нийт 7159.9 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж үйл ажиллагаа явуулсан байна.

Өөрөөр хэлбэл ОНХС-ийн тайлант оны нийт эх үүсвэрийн 95.4 хувийг ОНХНС-ын орлогын шилжүүлэг, 3.8 хувийг урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэр, 0.6 хувийг татварын хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр эзэлж байна.

1.2.3. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХСанд олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль журмыг баримталж хуваарилсан байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 3.2-т заасны дагуу Засгийн газрын 2012 оны 230 дугаар тогтоолоор баталсан аргачлалаар сум бүрээр хуваарилан тухайн шатны ИТХ хэлэлцүүлж жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор батлуулна гэсний дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 51 дүгээр тогтоолоор батлуулсан байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 3.2.2-т “Тухайн аймагт хуваарилагдсан ОНХС-ийн хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 59.2 дахь заалт болон Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын дагуу сум бүрээр хуваарилан аймгийн төсөв батлах тухай загвар маягтын гурав дахь хүснэгтийн 3.3.1-ийн 2-т оруулан тухайн аймгийн зарлагад оруулж тооцно. Энд тухайн аймагт хуваарилагдах ОНХС-ийн 40 хувийг мөн багтаасан байна” гэсэн заалтыг баримталж хуваарилсан байна.

Засгийн газрын 2012 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 8 дугаар зүйлийн 8.1-д “аймаг нь Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хуваарилсан орлогын шилжүүлгийг сумын хөгжлийн санд хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59.2-т заасны дагуу дараах байдлаар хуваарилна”, 8.1.1-д “ аймаг нь ОНХНС-аас шилжүүлсэн дүнгээс Төсвийн тухай хуулийн 59.2.1-д заасны дагуу суурь зардалд ногдох хэсгийг тухайн сумын ОНХС-д шууд хуваарилна” гэсний дагуу Хот тохижуулах газрын урсгал зардалд 21.5 сая төгрөгийг, Мал эмнэлгийн вакцинжуулалтын зардалд 332.4 сая төгрөгийг, нийт 353.9 сая төгрөгийг сумуудын Орон нутгийн хөгжлийн санд, аймгийн ХХААГ-т олгох мал эмнэлгийн үйлчилгээний хөлс 11.7 сая төгрөгийг аймгийн ОНХС-д хуваарилсан байна.

Төсвийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.2.4-д “энэ хуулийн 59.1.3, 60.2.5-д заасан эх үүсвэрийг хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллагаас хүлээн авагч талыг тусгайлан заасан тохиолдолд тухайн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй”, Засгийн газрын 2012 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 8.1.2-т “аймаг нь энэ аргачлалын 3.3-т заасны дагуу тооцсон эх үүсвэрийг тухайн сум, дүүргийн ОНХС-д шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөнд тооцохгүй” гэсний дагуу олон улсын төсөл, хөтөлбөрөөс олгосон урамшуулал 94.8 сая төгрөгийг, дэмжлэг 696.4 сая төгрөгийг буюу нийт 791.2 сая төгрөгийг сумуудын Орон нутгийн хөгжлийн санд батлагдсан дүнгээр хуваарилсан байна.

Дээрх аргачлалын 8.2-т “Аймаг нь ОНХНС-аас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн дүнгээс энэхүү аргачлалын 8.1-д зааснаас бусад хэсгийг “Төсвийн тухай хуулийн 59.2.2-т “энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах” гэсний дагуу сумын ОНХС-д хуваарилагдах дүнг тооцох бөгөөд энэ аргачлалын 8.1.1, болон 8.1.2-т заасны дагуу хөрөнгө хуваарилсан сумыг мөн багтаан тооцно” гэснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Аргачлалын 8.3-д энэ аргачлалын 8.2-т заасны дагуу хуваарилалтыг хийхдээ хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах үзүүлэлтийн хувийн жинг тооцохдоо 8.3.1-8.3.3-т заасны дагуу тооцохоор заасан байна.

8.3.1-д “Хүн амын тооноос хамаарах хувь-40 хувь”, 8.3.2-д “Алслалтаас хамаарах хувь-30 хувь”, 8.3.3-т “нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах хувь-30 хувь” гэсний хэрэгжилтийг шалгахад:

Сангийн яамнаас ОНХНС-аас аймагт хуваарилагдсан дүнг аргачлалын 8.3.1-8.3.3-т заасны дагуу сум бүрээр хуваарилсан жагсаалтыг ирүүлсэн байна.

Аймгийн СТСХ-ээс Ногооннуур сумын бүрэлдэхүүнд багтдаг Цагааннуур тосгонд ногдох хэмжээг тооцож хуваарилсан бөгөөд Сангийн яамнаас ирүүлсэн жагсаалтад ямар нэг өөрчлөлт оруулахгүйгээр аймгийн ИТХ-д оруулж батлуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 51 дүгээр тогтоолоор аймгийн ОНХСангаас сумдын ОНХСанд хүн амын нягтрал, алслалт, нутаг, дэвсгэрийн хэмжээнээс хамааруулан олгох орлогын шилжүүлгийг 1786.6 сая төгрөг, ашигт малтмал, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн 50 хувь гэсэн үзүүлэлтээр сумуудад 169.8 сая төгрөг хуваарилан баталжээ.

ОНХНС-аас тус аймагт хуваарилсан орлогын шилжүүлгийн дүнгээс суурь зарлага ба урамшуулал, дэмжлэгт хуваарилсан хөрөнгийг хасаж тооцон 6125.1 сая төгрөгийн 68 хувийг буюу 4168.7 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 32 хувийг буюу 1956.4 сая төгрөгийг сумуудын ОНХС-д хуваарилсан нь Төсвийн тухай хуулийн 59.2.2-д 30-аас доошгүй хувийг сумуудад хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах гэсэнтэй нийцсэн байна.

ОНХНС-аас тус аймагт хуваарилагдсан 7181.2 сая төгрөгийн орлогын шилжүүлгийн 5 хувийг суурь зарлага эзэлж байна. Хуваарилагдсан урамшуулал, дэмжлэгийг оруулж тооцоход сумуудад нийтдээ 2747.6 сая төгрөг хуваарилагдсан

байна. Энэ нь ОНХС-аас олгосон орлогын шилжүүлгээс суурь зарлагыг хасаж тооцсон дүнгийн 39.7 хувийг эзэлж байна. Үүнийг өмнөх оны хуваарилалттай харьцуулбал:

Хүснэгт №5		сая төгрөгөөр		
ОНХС	2018 он	2019 он	Зөрүү	Өсөлтийн хувь
Аймгийн ОНХС	2451.7	4168.7	1,717.0	70.0
Сумуудын ОНХС	2118.0	2747.6	629.6	29.7
Дүн	4569.7	6916.3	2346.6	51.4

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2017, 2018 оны тогтоолууд

ОНХС-аас аймгийн ОНХСанд олгосон орлогын шилжүүлгийг өмнөх онтой харьцуулахад 2346.6 сая төгрөгөөр буюу 51.4 хувиар өссөн байна. Үүнээс: Аймгийн ОНХС-гийн орлогын шилжүүлэг өмнөх оноос 1717.0 сая төгрөгөөр буюу 70 хувиар, сумдын ОНХС-гийн орлогын шилжүүлэг 629.6 сая төгрөгөөр буюу 29.7 хувиар нэмэгджээ. ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалтыг аймаг, сумаар хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6		/ сая төгрөг /	
ймаг, сум	Төлөвлөсөн	Хуваарилсан	Илүү, дутуу
Алтай	178.1	162.0	- 16.1
Алтанцөгц	90.7	90.7	
Баяннуур	162.0	162.0	
Бугат	73.5	73.5	
Булган	318.2	318.2	
Буянт	94.9	94.9	
Дэлүүн	371.7	371.7	
Ногооннуур	225.0	229.2	4.2
Сагсай	136.4	136.4	
Толбо	127.7	127.7	
Улаанхус	233.8	233.8	
Цэнгэл	308.7	308.7	
Өлгий	345.4	345.4	
Цагааннуур	81.3	81.3	-
Аймаг	4,168.7	4,101.3	- 67.4
Дүн	6,916.2	6,836.9	- 79.3

Эх сурвалж: Аймгийн СТСХ-ээс авсан судалгаа

Тус аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн батлагдсан төсөв /суурь зарлагыг хасаж тооцоход/ 6916.2 сая төгрөг ба гүйцэтгэлээр 6836.9 сая төгрөг олгож, 79.3 сая төгрөгийг дутуу олгосон байна.

Үүнээс шалтгаалан аймгийн ОНХСанд 67.4 сая төгрөгийг, Алтай сумын ОНХС-нд 16.1 сая төгрөгийг дутуу олгосон байна. Аймгийн СТСХ-элтсээс 2019 оны санхүүжилтийг олгож дууссаны дараа оны эцэст төлөвлөгөөг программд дахин татуулахад зөрүү гарч дутуу санхүүжилтийг нөхөж олгох боломжгүй болсон байна. Алтай сумын санхүүжилтийн дутууг 2020 онд нэмж олгосон байна. Ногооннуур сумын ОНХС-д 2018 онд дутуу олгосон 4.2 сая төгрөгийг аймаг дахь Төрийн аудитын газрын албан шаардлагын дагуу нэмж олгосон байна.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭГ ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.

2.1. Аймгийн дүнгээр 2019 онд иргэдийн саналаар дэмжигдээгүй 2476.9 сая төгрөгийн 135 төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

2.1.1. Ихэнх сумууд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу төлөвлөөгүй байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 5 дугаар бүлэгт сум, дүүргийн түвшинд ОНХС-ийн хөрөнгийг төлөвлөх талаар 5.1-д “сум, дүүрэг, баг хорооны түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалыг баримтална” гэж заасан байна.

Аймгийн дүнгээр 2019 онд иргэдийн саналаар дэмжигдээгүй 2476.9 сая төгрөгийн 135 төсөл, арга хэмжээг жагсаалтад оруулж ИТХ-аар батлуулан хэрэгжүүлсэн байна. Үүнээс: Аймгийн ИТХ-аар иргэдийн саналаар дэмжигдээгүй 1687.5 сая төгрөгийн 50, сумуудын ИТХ-аар 789.4 сая төгрөгийн 85 төсөл, арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн байна.

Тухайлбал: Баяннуур сум 131.9 сая төгрөгийн 7, Бугат сум 65.5 сая төгрөгийн 11, Дэлүүн сум 30.0 сая төгрөгийн 1, Ногооннуур сум 196.6 сая төгрөгийн 25, Сагсай сум 32.4 сая төгрөгийн 5, Толбо сум 35.5 сая төгрөгийн 6, Улаанхус сум 31.3 сая төгрөгийн 6, Цагааннуур тосгон 73.2 сая төгрөгийн 5, Цэнгэл сум 17.0 сая төгрөгийн 3, Өлгий сум 176.0 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээг иргэдийн саналаар дэмжигдээгүй байхад жагсаалтад оруулж ИТХ-аар батлуулж, хэрэгжүүлсэн байна.

Дээрх байдал нь Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлийн 12.2-т “сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог дараах байдлаар хангана”, 12.2.1-т “баг хорооны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг явуулна”, 12.2.1.а-д “баг, хорооны иргэдээс санал асуулгыг авахдаа санал асуулгын хуудсаар, бүлгийн ярилцлага, цахим хэлбэрээр авна”, 12.2.4-т “баг, хорооны Засаг дарга иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн хөгжлийн бодлоготой уялдсан төслийн санал болон иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг тухайн иргэдийн Нийтийн Хуралд хэлэлцүүлж, тус хурлаас эрэмбэлэгдэн гарсан төслийн жагсаалтыг сум, дүүргийн Засаг даргад 2 дугаар улиралд багтаан хүргүүлнэ” гэснийг тус тус зөрчсөн байна.

2019 онд ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдаагүй 779.2 сая төгрөгийн 43 төсөл, арга хэмжээг жагсаалтад оруулж ИТХ-аар батлуулан хэрэгжүүлсэн байна. Тухайлбал: Алтанцөгц сум 55.4 сая төгрөгийн 3, Баяннуур сум 152.4 сая төгрөгийн 6, Бугат сум 51.0 сая төгрөгийн 9, Дэлүүн сум 368.0 сая төгрөгийн 6, Ногооннуур сум 122.0 сая төгрөгийн 14, Улаанхус сум 20.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь урьдчилж батлагдаагүй, барилгын зураг төсөлд магадлал хийгдээгүй байхад эрэмбэлсэн жагсаалтад оруулж сумын ИТХ-ын тогтоолоор батлуулж, хэрэгжүүлсэн байна. Толбо сум 10.0

сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг холбогдох шаардлага, стандартыг баримталж боловсруулаагүй байна.

Аудитын дүнгээр дээрх зөрчлүүдийг давтан гаргахгүй байх талаар аймаг, сумуудын Засаг дарга нарт албан шаардлага өгөгдсөн болно.

2.1.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээ орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан боловч холбогдох журам, зааврын дагуу төлөвлөгдөөгүй байна.

Аймгийн Засаг даргын ажлын албанаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргаж 2018 оны 11 дүгээр сард төсвийн төслийн хамт аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 51 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг баталсан.

Тогтоолын хавсралтад 2018-2019 оны төсвийн жилд хэрэгжүүлэх 1667.9 сая төгрөгийн 15 шилжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, 2019 онд шинээр эхлэх 2500.8 сая төгрөгийн 58 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ буюу нийт 4168.7 сая төгрөгийн 73 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хуралдааны “2018 оны жилийн эцсийн төсвийн үлдэгдлийг хуваарилах, зарим хөрөнгийн нэрийг өөрчилж тодотгон батлах тухай” 66 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны үлдэгдлээс 1 төсөл, арга хэмжээний батлагдсан төсвийг 60.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 27.2 сая төгрөгийн шинээр эхлэх 4 төсөл арга хэмжээг нэмж төлөвлөж, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг 87.2 сая төгрөгөөр тодотгож баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Аймгийн 2019 оны төсөвт зохицуулалт хийх, хэмнэлттэй зардлуудыг зарцуулах тухай” 71 дүгээр тогтоолоор аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хэмнэлтээс Өлгий сумын 2 дугаар багийн 2ш гүний худгийн үнэд 11.2 сая төгрөгийг, аймгийн 2019 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хэмнэлтээс 67.4 сая төгрөгийг 5 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар баталсан байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 4.1-д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр болон орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан байх”, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.1-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх” гэж заасан.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ аймгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр болон аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдсан боловч төлөвлөх үйл ажиллагаа нь Төсвийн тухай хууль болон “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

Тухайлбал: “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 6.2-т “аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр дараа жил хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг тухайн аймаг, нийслэлийн хөгжлийн бодлого, чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөрт туссан үйл ажиллагаа, урьд онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг харгалзан боловсруулна”, 6.4-т “Урьдчилсан саналын жагсаалтыг аймаг, нийслэлийн дэргэдэх Иргэний танхимаар нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд зохион байгуулна”, гэснийг хэрэгжүүлээгүй,

6.5-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга иргэний танхимаар хэлэлцүүлсэн төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий 7-оос доошгүй хүнтэй ажлын хэсгийг Засаг даргын тамгын газар, Хөгжлийн бодлогын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтсийн холбогдох ажилтнууд болон иргэний нийгмийн төлөөлөл оролцуулан хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулан байгуулна” гэсний дагуу ажлын хэсгийг байгуулаагүй байна.

Аймгийн Засаг даргын байгуулсан ажлын хэсэг нь Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 6.6-д “Аймаг, нийслэлийн засаг дарга иргэд, олон нийтээс хамгийн их санал, ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн иргэд, олон нийтэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон иргэний танхимаар дамжуулан 11 дүгээр сарын 30-ны дотор танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулна” гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Ажлын хэсэг нь сумууд болон байгууллагуудаас албан бичгээр ирүүлсэн саналыг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад оруулж батлуулсан боловч 1687.5 сая төгрөгийн 50 хөтөлбөр, төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс эрэмбэлж иргэд, олон нийтийн саналгүйгээр жагсаалтад оруулж аймгийн ИТХ-ын тогтоолоор батлуулсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх гэснийг хэрэгжүүлж ажилласан эсэхийг шалгахад үүнийг нотлох ажлын баримт, материал байхгүй байна.

Аймгийн ОНХС-ийн ажлын хэсэг нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт гаргаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамааралгүй улсын төсвийн байгууллагуудад 149.1 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн ОНХС-ийн төлөвлөгөөнд оруулж батлуулсан нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2-д “ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно”, 4.2.5-д “Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал” гэсэнтэй нийцээгүй байна.

Дэлүүн сумын “Нур” хувийн эмнэлэгт 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг аймгийн ОНХС-ийн төлөвлөгөөнд оруулан батлуулж, хэрэгжүүлэн ОНХСангийн төсвийг хууль бусаар зарцуулсан байна. Энэхүү асуудлыг гэмт хэргийн шинжтэй байна гэж үзэж Прокурорын байгууллагад шалгуулах саналаа Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүлэв.

Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 6.1-д “аймаг, нийслэлийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ыг баримтална гэж заасан боловч хэрэгжилт нь хангагдаагүй байна.

Дээрх байдал нь “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлийн 12.1-т “аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог дараах байдлаар хангана”, 12.1.1-т “аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалт боловсруулж, жил бүрийн 3 дугаар улиралд багтаан иргэд, олон нийтийн саналыг авна”, 12.1.2-т “иргэд олон нийтийн саналыг цахим хуудас, санал асуулгын хуудас ашиглах, ярилцлага зохион байгуулах болон дэвшилтэт технологийн бусад хэлбэр ашиглах замаар явуулна”, 12.1.3-т “аймаг, нийслэлийн Засаг дарга олон нийтээс хамгийн их санал авсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн, иргэд олон нийтэд танилцуулна”, 12.1.5-т “аймаг нийслэлийн Засаг дарга олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулснаар нийтийн эрх ашигт нийцсэн, эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, энэ журмын 6.3-д заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гарган тухайн шатны ИТХ-д төсвийн төслийн хамт өргөн мэдүүлнэ” гэснийг,

Мөн Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар бүлгийн 3.1-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дараах нөхцөлүүдийг хангасан байна”, 3.1.2-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх”, 3.1.3-т “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх”, 3.1.7-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлттэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон

нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах”, 4.3-т “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал нь энэ журмын 3 дугаар бүлэгт заасан нөхцөлийг хангаагүй, мөн 4.2-т заасныг хэрэгжүүлэхээр бол нэгдсэн жагсаалтаас хасах үндэслэл болно”, 4.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан чиг үүрэгт хамаарах энэ журмын 4.2-т зааснаас бусад хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх ажлыг санхүүжүүлнэ”, 4.2-т “ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно”, 4.2.5-д “Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал” 8.5-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2016 оны “Журам шинэчлэн батлах тухай” 415 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-д зааснаар захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу төлөвлөөгүй байгаа зөрчлүүдийн дүнгээр аймгийн Засаг дарга, Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т, мөн сумуудын Засаг дарга нарт албан шаардлага өгөгдлөө.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2018 оноос он дамжин хэрэгжиж байгаа Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 1139.4 сая төгрөгийн өртөгтэй барилга, 8 дугаар цэцэрлэгийн 1208.3 сая төгрөгийн барилгын ажлуудын хөрөнгийн эх үүсвэрийг 2018-2021 онуудад жил бүр 250.0-300.0 сая төгрөгөөр хувааж төлөвлөн 3-4 жил үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын үр ашиг, үр өгөөжийг бууруулахад хүргэсэн байна.

Цаашид аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шинээр барилга барих ажлуудыг тухайн ондоо багтаан хэрэгжүүлэх, он дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулахгүй байх талаар анхаарч ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөмж болгов.

2.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллаагүй байна.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд нийтдээ шилжих хөрөнгө оруулалтаар 2458.3 сая төгрөгийн 63, шинээр эхлэх 5235.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 333 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 2413.4 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний 20 ажлын гүйцэтгэгчийг нээлттэй тендер

шалгаруулалтаар, 1490.2 сая төгрөгийн өртөгтэй 54 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулан гэрээ байгуулж, 1947.5 сая төгрөгийн өртөгтэй 293 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байна.

Сумууд 10.0 сая төгрөгөөс доош өртөгтэй төсөл арга хэмжээг шууд гэрээгээр хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн цэвэрлэх байгууламжийн 2ш карт тавих 60.0 сая төгрөгийн ажлыг аймгийн Онцгой комиссын шийдвэрээр “Суат” ХХК ОНӨААН-д шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг аймгийн Орон нутгийн өмчийн газар, сумуудын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг сумын ЗДТГазар зохион байгуулж явуулсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд болон аймгийн bayanulqii@gov.mn цахим сайтад тухай бүр байршуулан, аймгийн Орон нутгийн олон нийтийн радиогоор давхар зар өгсөн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д “Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна” гэсний хэрэгжилтийг шалгахад:

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан үнэлгээний хороо, аймгийн Засаг даргын захирамжаар тухайн байгууллагад эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг байгууллагын удирдлагын томилсон үнэлгээний хороо, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг сумын Засаг даргын захирамжаар байгуулсан үнэлгээний хороо тус тус зохион байгуулж явуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу захиалагчаас тендер шалгаруулалтыг зохион байгуулж, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн А-З сертификаттай хүнийг оруулж, 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон

нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна” гэсэн заалтын дагуу үнэлгээний хороог байгуулаагүй байна.

Тухайлбал: Аймгийн Засаг даргын байгуулсан 23 төсөл, арга хэмжээний үнэлгээний хорооны гишүүний бүрэлдэхүүнд аймгийн ЗДТГ-ын 2-3 ажилтныг буюу аймгийн Засаг даргын ажлын албаны хүмүүсийг томилон ажиллуулсан нь ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн байна гэж үзэх үндэстэй байна.

Үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан боловч хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгчийг оролцуулна гэснийг огт хэрэгжүүлээгүй, Үнэлгээний хороонд оруулсан иргэнийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилоогүй бөгөөд Үнэлгээний хорооны гишүүдээр томилогдсон иргэд тендерийн шалгаруулалтын үйл ажиллагаанд оролцдоггүй байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулахаар томилогдсон үнэлгээний хорооны зарим гишүүдээс үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулж аваагүй, үнэлгээний хорооны зарим гишүүд тендерийн бичиг баримт боловсруулах хурал, тендерийн нээлтийн хурал, тендер шалгаруулалт зэрэгт оролцоогүй байна.

23 төсөл, арга хэмжээний үнэлгээний хорооны гишүүнээр томилогдсон нийт 125 гишүүний 45 нь Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын хавсралтыг буюу үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг бөглөөгүй байна.

Мөн дээрх 125 гишүүний 46 нь ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргаж өгөөгүй, 13 төсөл, арга хэмжээний үнэлгээний хорооны гишүүнээр томилогдсон иргэний төлөөлөл нь тендерийн бичиг баримт боловсруулах хурал, тендерийн нээлтийн хурал, тендер шалгаруулалт зэрэгт огт оролцоогүй байна.

Тендер шалгаруулалтыг аймгийн Засаг даргын томилсон ажлын албаны хүмүүс ихэвчлэн явуулсан, иргэдийн оролцоо хангалтгүй, хувийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг огт оролцуулаагүй байгаа нь тендер шалгаруулалтыг хуулийн дагуу явагдсан гэж үзэх үндэслэлгүй байна.

Дээрх байдал нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7-ийн “Үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд хорооны гишүүдийн олонх дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох бүх мэдээллийг агуулсан байна”, 47.8-д “Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах,

хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана”, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг төслийг боловсруулан захиалагчаар батлуулаагүй байгаа нь Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 3.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Тендерийн бичиг баримтуудыг хууль журмын дагуу боловсруулж ажилласан боловч зарим шалгуур үзүүлэлтүүдийг буруу сонгосон тохиолдол байна. Тухайлбал: Буянт сумын Өмнө гол багийн модон гүүрний ажлын тендерийн бичиг баримтын тендер шалгаруулалтын өгөгдөлд боловсон хүчний шаардлагыг зам гүүрний инженер биш барилгын инженер гэж оруулсан байгаа нь шаардлага хангахгүй байна.

Мөн компаниудын ирүүлсэн материалыг сайн нягталж шалгадаггүй байна. Тухайлбал: Буянт сумын Өмнө гол багийн модон гүүрний ажлын тендерт оролцохоор материал ирүүлсэн “Асгант кент” ХХК нь инженер техникийн 3 ажилтандаа 2015 оноос ажилд томилсон тушаал, НДШ төлсөн ажилчдын жагсаалтын хамт ирүүлсэн боловч, шимтгэл төлдөг 26 ажилтны дотор тухайн 3 инженерийн нэр байхгүй илт хуурамч материал ирүүлсэн байхад шалгаруулсан байна.

Хуульд заасны дагуу ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үнэлгээний хорооноос гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, аймгийн Засаг дарга болон сумуудын ЗДТГ-т гэрээ байгуулах тухай зөвлөмж хүргүүлсэн байна.

Тендерт шалгарсан компанитай ажил гүйцэтгүүлэх гэрээг Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар батлагдсан тендерийн жишиг баримт бичигт заасны дагуу тендер шалгаруулалтын гэрээний маягтаар зохих журмын дагуу байгуулжээ.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.1-д “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална” гэснийг хэрэгжүүлэн ажилласан эсэхийг шалгахад:

Зарим төсөл арга хэмжээний бараа, ажил, үйлчилгээний тухай товч тодорхойлолт, тендерийн баримт бичиг, захиалагч, тендерт оролцогчтой харилцсан албан бичиг, тендерт оролцогчоос ирүүлсэн тендерийн бичиг баримтууд, тендерийн нээлт хийсэн тэмдэглэл, тендер шалгаруулалт амжилтгүй болсон эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэлийн талаар холбогдох нотлох баримтууд байхгүй, тендер шалгаруулалттай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг дутуу, CD диск-д хуулж цахимаар архивлаагүй байна. Мөн гэрээг дүгнэж бараа, ажил үйлчилгээг хүлээж авсан бичиг баримтыг бүрдүүлж аваагүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.2-т “Тендерийн хавтаст хэрэг дараах баримт бичиг, материалаас бүрдэнэ”, 49.2.1-д “худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, шаардлагатай бол тайлбар”, 49.2.3-т

“худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тухай товч тодорхойлолт, тендерийн баримт бичиг”, 49.2.4-т “захиалагч, тендерт оролцогчтой харилцсан албан бичиг”, 49.2.5-д “тендерт оролцогчдын ирүүлсэн тендер”, 49.2.6-д “тендерийн нээлтийн тэмдэглэл, үнэлгээний дүгнэлт, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж”, 49.2.7-д “тендер шалгаруулалт амжилтгүй болсон, эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл”, 49.2.8-д “гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр, гэрээ”, 49.2.9-д “тухайн тендер шалгаруулалттай холбоотой бусад баримт бичиг”, 49.2.10-т “гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.2.2-т “аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн орон нутагт худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд, 45.3-т “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газар захиалагч байна”, 45.6-д “Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь шаардлагатай гэж үзвэл сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт энэ хуулийн 45.2.2-т заасан эрхээ шилжүүлж болно”, 46 дугаар зүйлийн 46.1.6-д “захиалагч нь бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавина” гэж заасны дагуу аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын дарга нар захиалагчийн үүргийг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн болон Өлгий сумын ОНХСангаас хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн захиалагчийн хяналтыг аймгийн Барилга захиалагчийн албанд хариуцуулж, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан байна. Барилга захиалагчийн албанд 2019 онд хяналтын зардалд аймгийн ОНХС-аас 64.7 сая төгрөг, Өлгий сумын ОНХС-аас 5.6 сая төгрөг тус тус шилжүүлсэн байна.

Барилга захиалагчийн алба захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж барилга, их засварын ажлыг зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн эсэхэд болон талбайд хийж гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ, хугацаа, чанар, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажилласан боловч энэ нь хангалтгүй байна.

Баяннуур, Бугат, Дэлүүн Ногооннуур, Сагсай, Улаанхус сумууд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрт захиалагчийн зүгээс хяналт тавьж ажиллаагүй байна. Тухайлбал: Дэлүүн сумын 99.2 сая төгрөгийн өртөг бүхий Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн шинээр баригдсан барилгад сумын ЗДТГ газар нь Барилга захиалагчийн албатай гэрээ байгуулаагүйгээс захиалагчийн хяналт хэрэгжээгүй ба барилгын ажил чанаргүй болсноос барилгын хана гадна болон дотор талаасаа цуурсан байна.

Барилга захиалагчийн албатай гэрээ байгуулахгүйгээр сумын ЗДТГ барилгын ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлсэн нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 5.1-т “Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналт тавьж, хэмжилт шалгалтыг барилгын салбарт мөрдөж байгаа хууль болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан норм, норматив, дүрэм журмын дагуу явуулна” 5.2-т “Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл,

чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аудитын явцад аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн байдлыг аймаг, сумдад газар дээр нь явж шалгаж үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

Аймгийн ОНХС-гаас хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдтэй захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэнтэй холбоотой илэрсэн зөрчлүүд:

- “Бапкер” ХХК гүйцэтгэсэн Өлгий сумын Иргэний танхимын 30.0 сая төгрөгийн их засварын ажлыг комисс хүлээн авч ашиглалтад оруулсан боловч засварын ажил чанаргүй хийгдсэн, Барилга захиалагчийн алба захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлээгүй.
- “Кендала” ХХК-ны гүйцэтгэсэн Сагсай сумын гэрэлтүүлгийн 27.9 сая төгрөгийн ажлын гэрэлтүүлгийн 9 багана дутуу хийгдэж гүйцэтгэл дутуу байхад барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын актаар 100 хувь хэрэгжүүлсэн гэж хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон.
- “Досстрой” ХХК-ны гүйцэтгэсэн Толбо сумын ЭМТ-ийн гал тогооны засварын ажлыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс чанартай сайн хийгдсэн гэж хүлээж авсан боловч засварын ажил хангалтгүй хийгдсэн.
- Өлгий сумын 2 дугаар багт “Хотын цамхаг” ХХК-ны хэрэгжүүлсэн 91.4 сая төгрөгийн, 11 дүгээр багт “Иел” ХХК-ны хэрэгжүүлсэн цэвэр усны шугам тавих 155.3 сая төгрөгийн ажлууд чанаргүй хийгдсэн. 2 жил болж байхад дээрх цэвэр усны шугамд нэг ч өрх холбогдоогүй, ашиглаагүй байна. Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг бодитой тодорхойлоогүйгээс хөрөнгө оруулалт үр өгөөжгүй болсон.
- Өлгий сумын 3 дугаар багт “Иел” ХХК-ны гүйцэтгэсэн 65.0 сая төгрөгийн 4 ш ухаалаг худгийн 2 нь ажиллагаагүй, карт уншигч төхөөрөмж нь эвдэрсэн, худгийн ойр орчмын газар цөмөрсөн байдалтай байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим чанаргүй төсөл, арга хэмжээг зургаар харуулбал:



Толбо сумын ЭМТ-ийн гал тогооны засварын ажил



Өлгий сумын Иргэний танхимын засвар



Өлгий сумын 11 дүгээг багийн цэвэр усны шугам



Өлгий сумын 3 дугаар багийн 2ш ухаалаг худаг

Сумуудын ОНХС-гаас хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдтэй холбоотой илэрсэн зөрчлүүд:

- Дэлүүн сумд 30.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Мах хадгалах зоорь”-ийн барилгын ажлыг ашиглалтад хүлээн авсан боловч гэрээг дүгнээгүй, хөлдөөх төхөөрөмж нь эвдэрсэн, ЕБ-ын 3 дугаар сургуулийн 100.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр баригдсан барилгын хана цуурсан, 2 дугаар хүүхдийн цэцэрлэгийн 10.0 сая төгрөгийн тохижилт, 11.0 сая төгрөгийн Паркын засварын ажил, 8.0 сая төгрөгийн өндөр хүчдэлийн шугамын багана тавих ажлуудын хэрэгжилтэд сумын ЗДТГ-аас захиалагчийн хяналтыг өөрсдөө хариуцаж хэрэгжүүлсэн гэх боловч хяналтыг хэрэгжүүлээгүйгээс чанаргүй хийгдсэн.
- Баяннуур сумын 15.0 сая төгрөгийн ЕБ-ын 1 дүгээр сургуулийн дотуур байрны худаг, тоног төхөөрөмжийг гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгосон, 19.8 сая төгрөгийн 1 дүгээр багт трансформатор тавих ажил, 5.0 сая төгрөгийн Цагаан-арал багийн Улаан буланд хийсэн засварын ажил, сумын ЗДТГ-т завь худалдан авах 10.0 сая төгрөгийн ажлуудыг комисс хүлээж аваагүй байхад санхүүжилтийг нь олгосон.
- Улаанхус сумын Ойгор багийн хүүхдийн цэцэрлэгт нийлүүлсэн 6.0 сая төгрөгийн тоглоом, 5.0 сая төгрөгийн сумын төвийн хүүхдийн цэцэрлэгийн хашаа татах ажлууд дутуу хэрэгжсэн байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.
- Бугат сумын 66.8 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад захиалагчийн зүгээс хяналт тавьж ажиллаагүй, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулах комисс хүлээж аваагүй, комиссын дүгнэлт гараагүй байхад санхүүжилт олгосон.
- Ногооннуур сумын Чихтэй багийн хүн эмнэлэгт 9.0 сая төгрөгийн эсгий гэр, тоног төхөөрөмжийг дутуу нийлүүлснээс комисс одоог хүртэл хүлээж аваагүй, комиссын дүгнэлт гараагүй, 8.0 сая төгрөгийн Малын угсармал хашааг хямд материалаар чанаргүй хийсэн, гүйцэтгэлийн тайлан гаргаагүй, комисс хүлээж аваагүй.
- Цагааннуур тосгоны захирагчийн албанд хашаа барих 8.0 сая төгрөгийн, 13-ын зам засах 7.0 сая төгрөгийн, Царгас тариалах 8.0 сая төгрөгийн, Хавцлын амнаас сум хүртэл чулуу татах 6.0 сая төгрөгийн, Балаг багийн Ёлтын зам засах 4.0 сая төгрөгийн, нийт 33.0 сая төгрөгийн ажлуудын гэрээний хугацаа дууссан боловч ажлын гүйцэтгэлийг хүлээлгэж өгөөгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-т “Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараах эрх, үүрэгтэй байна”, 46.1.6-д “бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих”, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 5.1-т “Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналт тавьж, хэмжилт шалгалтыг барилгын салбарт мөрдөж байгаа хууль болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан норм, норматив, дүрэм журмын дагуу явуулна”, 5.2-т “Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага нь барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн

зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллана” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.



Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль

Илэрсэн зөрчлүүдийг арилгуулахаар аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, холбогдох сумын Засаг дарга нарт албан шаардлага өгөгдлөө.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2018-2021 онуудад хэрэгжиж байгаа Өлгий сумын 8 дугаар цэцэрлэгийн барилгын ажлын зураг төсөв нь 1251.0 сая төгрөгөөр хийгдсэн байхад ажлыг хоёр багц болгон хувааж, эхний багцын тендерийг 2018 онд 600.0 сая төгрөгөөр зарлаж, тендерийн шаардлагыг хангаагүй тендер ирүүлсэн, тусгай зөвшөөрөлгүй “Алтан шар говь” ХХК-ийг хууль бусаар сонгон шалгаруулж, 2020 онд үлдсэн 600.0 сая төгрөгийн ажлыг тендер шалгаруулахгүйгээр уг компаниар гүйцэтгүүлэхээр үргэлжлүүлэн гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өлгий сумын 8 дугаар цэцэрлэгийн барилгын ажлын худалдан авах ажиллагааг хууль зөрчиж зохион явуулсан бөгөөд гэмт хэргийн шинжтэй гэж үзэж Прокурорын байгууллагаар шалгуулахаар саналаа Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүлэв.

2.2.2. Аймаг, сумын ОНХС-гаас нийтдээ 131.4 сая төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Аймгийн хэмжээгээр ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд нийтдээ 7239.2 сая төгрөгийн өртөгтэй 377 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 6851.5 сая төгрөгийн 353 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгч байгууллага, иргэдтэй гэрээ байгуулж ажилласан байна.

Үүнээс 6557.7 сая төгрөгийн 325 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 190.5 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна. Бүрэн хэрэгжсэн 325 төсөл арга хэмжээнүүдээс 55 төсөл, арга хэмжээний 115.6 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна. Энэ нь дутуу олгогдсон хяналтын зардал, зураг төсвийн үнэ, дутуу санхүүжилт бөгөөд ОНХС-ийн дансанд үлдэгдэлтэй гарсан байна.

Аймаг, сумын дүнгээр 128.9 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 2 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэний нэг нь гүйцэтгэгч компани гүйцэтгэлээ ирүүлээгүй байгаатай холбоотой, нэг нь гэрээ байгуулаагүй ажил байна.

Алтанцөгц, Баяннуур, Бугат, Дэлүүн, Ногооннуур, Улаанхус сумууд тайлант онд өмнөх оны ажлын санхүүжилтийг олгосноос, 2019 оны зарим төлөвлөсөн ажлын санхүүжилтийг олгож чадаагүй тул хэрэгжээгүй байна.

Гүйцэтгэгч байгууллагын ажлын гүйцэтгэлийн баримт болон барилга, их засварыг ашиглалтад өгөх актад захиалагчийг төлөөлж Барилга захиалагчийн албаны дарга, хяналтын инженерүүд гарын үсэг зурж баталгаажуулсны үндсэн дээр ХОХБТ-ийн хэлтэс хяналтын хуудсаар давхар хяналт тавьж Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-д заасны дагуу хяналтын хуудсыг бөглөж, баримтуудыг бүрдүүлж ирүүлсний дараа Санхүү, төрийн сангийн хэлтэс гэрээний дагуу санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг шалгахад Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 25.6, Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 28.7 Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.5, 10.3.2 дахь заалтуудыг зөрчсөн дараах зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоосон болно. Үүнд:

- Нэгдсэн эмнэлгийн рентген аппаратын засварын ажлын гүйцэтгэлийн санхүүжилтээс суутгасан 0.95 сая төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлээгүй.
- Буянт сумын Эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмж нийлүүлэх 18.5 сая төгрөгийн ажлын урьдчилгаанд “Аулет” хоршоонд 5.5 сая төгрөг шилжүүлсэн боловч гүйцэтгэгч байгууллага гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж чанаргүй тоног төхөөрөмж нийлүүлснээс ашиглагч байгууллага уг хөрөнгийг хүлээж аваагүй, төсвөөс олгосон хөрөнгийг тооцоо хийж, буцаан төлүүлэх арга хэмжээ аваагүй.
- Ногооннуур сумын Сум дундын эмнэлгийн 39.9 сая төгрөгийн засварын ажлын гүйцэтгэлд “Нармаржан” ХХК-нд 40.8 сая төгрөгийн санхүүжилт олгож гэрээний дүнгээс 0.9 сая төгрөгийг илүү шилжүүлсэн.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг шалгахад Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.2, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь заалтуудыг зөрчсөн дараах зөрчлүүдийг арилгуулах талаар албан шаардлага өгөгдлөө. Үүнд:

- Орон нутгийн хөрөнгө оруулалтын сангаас санхүүжих ёстой Өлгий сумын 12 дугаар багт хийгдсэн ундны усны 2 ш гүний худгийн зураг төсвийн үнэд 0.25 сая төгрөг, Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасгийн их засварын ажлын санхүүжилтэд 4.6 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн данснаас олгосон.
- Аймгийн ОНХС-ийн данснаас сумын Засаг дарга нарын зөвлөгөөний зардалд 22.0 сая төгрөг, Өлгий сумын 1 дүгээр хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төслийн үнэд 7.9 сая төгрөг бүгд 29.9 сая төгрөгийг эргэн төлүүлэх нөхцөлөөр олгож, үүнээс зөвлөгөөний зардлын 22.сая төгрөгийг эргэн төлүүлж, 1 дүгээр цэцэрлэгийн барилгын зураг төслийн үнийг төлүүлж аваагүй.

Мөн сумуудын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтыг шалгахад илэрсэн дараах зөрчлүүдийг арилгуулах талаар албан шаардлага өгсөн. Үүнд:

- Алтанцөгц сум Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн программ, принтер худалдан авахад 1.0 сая төгрөг зарцуулсан.
- Тэжээлийн нөөц бий болгох нэрээр Баяннуур сум 5.0 сая төгрөг, Улаанхус сум 6.4 сая төгрөгийн өвс худалдан авч сумын Засаг даргын захирамжаар малчдад үнэгүй тараасан.
- Бугат сум Цагдаагийн хэсгийн төлөөлөгчид 6.0 сая төгрөгөөр авто машин, Улаанхус сум хэсгийн төлөөлөгчид 2.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, Ногооннуур сум Цагдаагийн пост барихад 8.0 сая төгрөг зарцуулсан.
- Ногооннуур сум Сум дундын эмнэлгийг багаж хэрэгслээр хангахад 8.0 сая, Цагааннуур тосгоны захирагчийн албаны хашаа барихад 8.0 сая /Цагааннуур тосгоны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ёстой байсан/, Гамшгаас хамгаалах сургалтын хувцас, шатахуун, бусад зардалд 5.0 сая төгрөг, цахилгаанчдыг мотоциклээр хангахад 3.6 сая төгрөг зарцуулсан.
- Газар тариалан, ногоон байгууламжийг дэмжих нэрийдлээр Бугат сум 4.5 сая төгрөг, Ногооннуур сум 4.8 сая төгрөгийг хувь хүн, иргэн, аж ахуйн нэгжид олгосон.
- Дэлүүн сум сургуулийн дотуур байранд 5.8 сая төгрөг, Ногооннуур сум 2 дугаар цэцэрлэгт 1.5 сая төгрөг, Улаанхус сумын 2, 3 дугаар сургууль, Хөх хөтөл багийн эмнэлэгт 6.4 сая төгрөгийн зөөлөн эдлэл худалдан авч сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан.
- Алтанцөгц, Баяннуур, Бугат, Дэлүүн, Ногооннуур, Улаанхус сумууд баяр наадамд тус бүр 5.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан боловч журамд заасан шагналын жишиг хэмжээг баримталж ажиллаагүй, элдэв төрлийн спортын арга хэмжээ, хувцас, шатахуун болон бусад арга хэмжээнд бүрдэл дутуу баримтаар зарцуулсан.
- Сумуудын ОНХС-ийн үйл ажиллагаанаас гэрээг дүгнээгүй, гэрээний хугацаа дууссан боловч хийгдсэн ажлыг хүлээлгэж өгөөгүй, ажлыг дутуу гүйцэтгэсэн, бараа материал, хөрөнгийг дутуу нийлүүлсэн, ажлыг комисс хүлээж аваагүй, дүгнэлт гаргаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг нийтлэг зөрчлүүд оршиж байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.1-т “орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад

хөтөлбөр, арга хэмжээ”, Сангийн сайдын 2018 оны 228 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1-т “Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан чиг үүрэгт хамаарах энэ журмын 4.2-т зааснаас бусад хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх ажлыг санхүүжүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Баяннуур сумын ОНХС-ийн хөрөнгөөр “Малжуулах төсөл”-д 38.0 сая төгрөг зарцуулсан асуудлыг аймаг дахь Төрийн аудитын газраас энэ оны 4 дүгээр сард иргэдийн өргөдлийн дагуу шалгаж, зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдсөн тул энэхүү аудитын зөрчлийн дүнд оруулаагүй болно.

2.2.3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж ашиглалтад оруулсан нийт 1285.9 сая төгрөгийн хөрөнгийг орлогод аваагүй, орон нутгийн өмчид бүртгээгүй байна.

Аймгийн хэмжээгээр ОНХС-ийн санхүүжилтээр 2019 онд 377 төсөл, арга хэмжээ, хөтөлбөр хэрэгжсэн ба аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж ашиглалтад оруулсан 757.1 сая төгрөгийн 16 хөрөнгийг, Алтай, Баяннуур, Бугат, Булган, Буянт, Дэлүүн, Ногооннуур, Толбо, Улаанхус сумууд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж ашиглалтад оруулсан 528.8 сая төгрөгийн 32 хөрөнгийг ашиглагч байгууллагад орлогод авхуулж, данс бүртгэлд тусгуулаагүй байна. Тухайлбал:

- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 оноос дамжин хэрэгжсэн болон 2019 онд шинээр хэрэгжсэн 757.1 сая төгрөгийн өртөгтэй 16 төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгө ашиглагч байгууллагуудад орлогод авагдаагүй, данс бүртгэлд тусгаагүй байна.
- Алтай сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж, ашиглалтад оруулсан Сумын төвд шинээр трансформатор тавих 9.8 сая төгрөг, 7.5 сая төгрөгөөр унаач хүүхдүүдийн дүрэмт хувцас худалдан авсныг орлогод авч, данс бүртгэлд тусгаагүй байна.
- Баяннуур сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны худаг ухах, тоног төхөөрөмж 15.0 сая төгрөг, Цэцэгт багт трансформатор тавих 19.8 сая төгрөг, Тэжээлийн нөөц бэлтгэх 5.0 сая төгрөг, Завь худалдан авах 10.0 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагууд орлого авч данс бүртгэлд тусгаагүй байна.
- Бугат сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Ерөнхий боловсролын сургуульд бөхийн дэвжээ нийлүүлэх ажлыг гүйцэтгүүлэхээр “Хүйтэн хошуу” ХХК-тай 10.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулан урьдчилгаанд 6.1 сая төгрөг шилжүүлж хөрөнгийг одоог хүртэл хүлээж аваагүй, данс бүртгэлд тусгаагүй байна.
- Булган сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж, ашиглалтад оруулсан Шинэ хүрээ аяллын бүсэд цэцэрлэгт хүрээлэн байгуулах 4.0 сая төгрөг, Бага ширээдийн адагт машины гүүр барих 6.5 сая төгрөг, Улаагчны голд мотоциклын гүүр барих 3.0 сая төгрөг, Улаантугт мотоциклын гүүр барих 5.0 сая төгрөг, Цөнхөл багийн Улаан хөдөөд мотоциклын гүүр барих 9.9 сая төгрөг, Улаанхус багийн Дунд төмөртийн голд мотоциклын гүүр барих 3.0 сая төгрөгийн, бүгд 31.4 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагууд орлогод авч данс бүртгэлд тусгаагүй байна.
- Буянт сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж,

ашиглалтад оруулсан Хөлцөөтийн зам 5.0 сая төгрөг, Сумын төвийг камержуулах 3.4 сая төгрөг, Сумын замын тэмдэглэгээ хаягжуулах 2.5 сая төгрөгийн, нийт 10.9 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагууд орлогод авч, данс бүртгэлд тусгаагүй байна.

- Дэлүүн сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж ашиглалтад оруулсан сумын төвд 297.5 сая төгрөгийн төсөвт өртгөөр баригдсан 860 метр бетон авто зам, 11.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр баригдсан Хүүхдийн паркийн тоглоомын засвар, тохижилтын ажлыг орлого авч данс бүртгэлд тусгаагүй байна.
- Ногооннуур сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж ашиглалтад оруулсан Чихтэй багийн хүн эмнэлгийн эсгий гэр ба тавилга 9.0 сая төгрөг, Цагааннуур тосгоны Захирагчийн албаны хашаа 8.0 сая төгрөг, Малын угсармал хашаа 8.0 сая төгрөг, Цахилгаанчдад мотоцикл авах 3.6 сая төгрөг, Сумын төвийн ногоон байгууламж 9.8 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагууд орлогод авч, данс бүртгэлд тусгаагүй байна.
- Улаанхус сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж ашиглалтад оруулсан Шүй-ащы худаг 8.7 сая төгрөг, Тэжээлийн фонд бий болгох 6.5 сая төгрөг, Даян багийн нүүдлийн хүн эмнэлгийн барилга 8.0 сая төгрөг, Хөх хөтөл эмнэлгийн хатуу, зөөлөн эдлэл 4.0 сая төгрөг, Согоог багийн цэцэрлэгийн тоглоом 6.0 сая төгрөг, Хөх хөтөл багийн цэцэрлэгийн тоглоом 4.0 сая төгрөг, Ахлах сургуулийн бөхийн дэвжээ 15.8 сая төгрөг, 3-р баг под станц 4.0 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагууд орлогод авч, данс бүртгэлд тусгаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д “захиалагч нь бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавина”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтуудыг зөрчсөн тул аймгийн СТСХэлтэс болон сумуудын ЗДТГ-т албан шаардлага өгөгдлөө.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЖ, ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.

3.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, Иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллаагүй байна.

Сангийн сайдын 2018 оны 228 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4-т “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина” гэж заажээ.

Дээрх журмын биелэлтийг шалгах зорилгоор аудитын явцад 13 сум болон холбогдох бусад газруудад 2019 онд хийсэн хяналт шалгалтын тайлан, холбогдох материалуудыг аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн боловч Алтай, Толбо сумаас бусад сум хяналт шалгалт хийсэн тухай материал ирүүлээгүй болно.

Аймгийн ИТХ, Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2019 онд ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй гэсэн хариуг албан бичгээр ирүүлсэн байна.

Алтай сумын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зарцуулалт, гүйцэтгэлд тухай бүр хяналт тавьж, гүйцэтгэлийн талаарх дүгнэлт гаргаж ажилласан байна. Толбо сумын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь тухайн онд хэрэгжүүлсэн 13 төсөл арга хэмжээнээс 2 төсөл арга хэмжээнд хяналт тавьж ажилласан байна.

Үүнээс үзэхэд аймаг, сумын ИТХ-аас ОНХС-ийн зарцуулалтад хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх талаар санаачилгагүй ажилласан байна.

Аймгийн ОНХС-ийн болон Алтай, Алтанцөгц, Дэлүүн, Ногооннуур, Сагсай, Толбо, Улаанхус, Цэнгэл, Өлгий сум, Цагааннуур тосгоны ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг Шилэн дансанд байршуулсан байна.

Баяннуур, Бугат, Булган, Буянт сумууд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний талаар Шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй байна.

Аудитын дүнгээр ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагатай хамт тогтмол хяналт тавьж ажиллах талаар аймаг, сумдын ИТХ болон Санхүүгийн хяналт, аудитын албанд зөвлөмж хүргүүлэв.

3.1.2. Аймаг, сумын захиргааны байгууллагууд ОНХС-ийн хэрэгжилт, үр дүнд хийх хяналт, шинжилгээ үнэлгээг холбогдох журмын дагуу хийж гүйцэтгээгүй байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.5-т “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 89 дүгээр тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд хийнэ”,

9.6-д “Энэ журмын 9.5-д заасны дагуу хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг ОНХС-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлэх үүргийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар хүлээнэ” гэж заажээ.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/756 дугаар захирамжаар томилогдсон Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг, Тогтвортой амьжиргаа-3 төслийн нэгжтэй хамтран Алтай, Баяннуур, Бугат, Ногооннуур, Сагсай, Толбо, Улаанхус, Цэнгэл, Өлгий сумуудын ОНХС-ийн 2019 оны төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хяналт шалгалт хийсэн байна.

Шалгалтыг алдаа зөрчлийг арилгах, зөвлөн туслах хэлбэрээр явуулсан боловч ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт болон үр дүнд дээрх журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.

Аудитын явцад аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 2019 онд ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад хяналт, шинжилгээ үнэлгээ хийгдээгүй, цахим хуудсанд мэдээлэл байршуулаагүй талаар албан бичгээр хариу ирүүлсэн.

Аудитын дүнгээр аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэст ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг зохих журмын дагуу хийж, үр дүнг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудсаар мэдээлж байх талаар зөвлөмж хүргүүлэв.

3.2. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар журмын дагуу тайлагнаж, хүргүүлж ажилласан байна.

3.2.1. ОНХСангийн төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийн тайланг Төсвийн тухай хууль болон журам, зааварт тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлж ажилласан байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.1-т “Дүүргийн төрийн сангийн хэлтэс, сумын санхүүгийн алба нь ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг энэ журмын 10 дугаар хавсралтын дагуу аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах хугацаанд тайлагнана”, 9.3-т “Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалтын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна” гэж заасан байна.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний тайланг сумдын Засаг даргын Тамгын газраас аймагт хүргүүлсэн байдлыг авч үзэхэд хагас жилийн тайланг бүх сум ирүүлсэн, бүтэн жилийн тайланг Цэнгэл сумаас бусад бүх сум ирүүлсэ байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/756 дугаар захирамжаар байгуулагдсан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 9 сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний явцын тайлан, мэдээг сум бүрээр танилцуулан цаашид анхаарах асуудлуудыг хэлэлцсэн байна.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2020 оны эхэнд сумдын Засаг дарга нарын тайланг хэлэлцэхдээ тухайн жилд сумын орон нутгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний дүнг сонгож хөрөнгө оруулалтын талаарх танилцуулгыг сонин, хэвлэмэл материал болгон гаргаж иргэдэд тарааж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж ажилласан байна.

Аймгийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн тайланд гарсан санал зөвлөмж, мэдээг хавсралт маягтын дагуу гаргаж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын төсвийн нэгтгэлийн хэлтэст 2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 1-01/166 дугаар албан бичгээр хүргүүлж, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

3.2.2 Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлсэн боловч тайлант онд алдаа, зөрчлийг давтан гаргасан байна.

Тус аудитын газраас ОНХС-ийн 2018 оны зарцуулалтад 2019 онд хийгдсэн нийцлийн аудитын дүнгээр нийтдээ 1755.8 сая төгрөгийн зөрчил илэрч, үүнээс 21.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1733.9 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлагыг өгөгджээ. Үүнд Сумдын ОНХСанд 1216.6 сая төгрөгийн, аймгийн ОНХСанд 517.3 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн

хэлтсийн даргад Орон нутгийн хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай холбоотой 1 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн байна.

Аймаг, сумдын ЗДТГ-ууд өгсөн албан шаардлага, зөвлөмжийн дагуу тодорхой ажил зохион байгуулж албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд гаргаж ирүүлсэн ба актын төлбөрийг бүрэн барагдуулжээ.

Энэ удаагийн аудитаар илэрсэн зөрчлийг өмнөх онуудад илэрсэн зөрчилтэй харьцуулж үзэхэд иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг жагсаалтад оруулж батлуулж хэрэгжүүлсэн, сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, үр өгөөж багатай төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн, ОНХСангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг данс бүртгэлд орлого аваагүй зэрэг зөрчлүүд давтагдан гарсан байна.

ОНХС-ийн 2017-2019 оны үйл ажиллагаанд хийгдсэн аудитын дүнгээр илэрсэн зөрчлийг харьцуулсан судалгаа.

Хүснэгт №7

Алдаа, зөрчлийн	2017 он	2018 он	2019 он	2017-2018 он		2018-2019 он	
				Зөрүү	Өсөлт хувиар	Зөрүү	Өсөлт хувиар
Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	1300.0	1755.8	5294.2	455.8	35.1	3538.4	201.5
Тоо	109	144	402	35.0	32.11	258	179.2

Эх сурвалж: Алдаа, зөрчлийг харьцуулсан судалгаа

Аймаг, сумын ОНХСангийн 2019 оны зарцуулалтад хийсэн аудитын дүнгээр илэрсэн зөрчлийг өмнөх онтой харьцуулахад зөрчлийн мөнгөн дүн 3538.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, албан тушаалтнуудын ажлын хариуцлагагүй байдалтай холбоотой байна.

График №1



Аймаг, сумын ОНХС-ийн 2019 оны зарцуулалтад хийсэн энэ удаагийн нийцлийн аудитын дүнгээр нийтдээ 5294.2 сая төгрөгийн зөрчил илэрч 7.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5286.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулахаар аймгийн ИТХ-д 2, аймгийн Засаг даргад 4, Орон нутгийн өмчийн газарт 1, Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэст 1, Санхүүгийн хяналт, аудитын албанд 1 заалт бүхий зөвлөмжийг тус тус хүргүүлээ.

3.2.3. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа нь орон нутгийн хөгжлийг дэмжихэд зохих үр дүнгээ өгч байгаа боловч орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим хууль журамд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.6-т “Энэ журмын 8.5-д заасан санхүүжилтийн эрхийн дагуу ОНХС-ийн Төрийн сан дах данснаас гүйлгээ хийх төлбөрийн хүсэлтийн баримтад аймаг, нийслэлийн хувьд 1 дүгээр гарын үсгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч, сум дүүргийн хувьд 1 дүгээр гарын үсгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг Засаг даргын Тамгын газрын ахлах нягтлан бодогч тус тус зурна” гэж заасан боловч зарим сумдын Засаг дарга нар эрх шилжүүлэлгүй, төлбөрийн хүсэлтийн баримтад 1 дүгээр гарын үсгийг зурж чиг үүрэгт хамаарахгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлдгээс төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул байна.

Ихэвчлэн аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч нарын сонгогдсон тойрогт зориулж төсөл арга хэмжээг дэмжиж оруулан ИТХ-аар батлуулж байна. Засаг дарга нар сонгуулийн үр дүнгээр солигддог тул улс төрийн албан тушаалтанд хариуцлага тооцуулахад хүндрэлтэй, энэ талаар хуульд тодорхой заалт байхгүй байна.

Иймд “ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хууль болон “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д иргэдийн олонхийн саналыг авч дэмжигдсэн, үр өгөөжтэй төсөл арга хэмжээг эрэмбэлж ИТХ-д оруулан батлуулна” гэсэн хатуу заалт оруулах, ОНХС-ийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэсэн заалтын дагуу Тамгын газрын дарга нар 1 дүгээр гарын үсэг зурдаг зохицуулалтыг журамд оруулах нь зүйтэй.

Журмын 4.2-т “ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно”, 4.2.5-т “Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал” гэж заасан боловч улсын төсвийн байгууллагуудад сангийн хөрөнгөөр тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авдаг, тусгай шилжүүлгийн байгууллагуудад урсгал зардал болох нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авдаг зөрчил давтагдан гарч байна.

Иймд Төсвийн тухай хууль болон “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын хориглосон заалтуудыг тодорхой болгох шаардлагатай байна.

Журмын 3.1.2-т “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх” гэсэн заалтын хүрээнд багийн түвшинд санал авах хуудсанд өөрийн хамаарал бүхий этгээдүүд болон танилуудаар гарын үсэг зуруулдаг эсвэл хуурамчаар гарын үсэг зурж, хувийн өмчийн газар тариалан, ногоон байгууламж, хадлан талбайд хөрөнгө шийдвэрлүүлдэг зөрчил мөн гарсан байна.

Санал авах хэлбэрийг ил тод цахимаар авдаг болгох талаар журамд өөрчлөлт оруулах, нотлох баримтад үндэслэн эрэмбэлсэн жагсаалтад оруулахаар зохицуулалт хийх шаардлагатай байна.

Журмын 3.1.3-т “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх” гэсэн заалтыг зөрчиж зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлгүй төсөл арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн, зураг төсвийг батлагдсан төсөвт тааруулж хийлгэдэг, зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлд магадлал хийлгэдэггүй зөрчил нийтлэг байна.

Иймд зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлд заавал магадлал хийлгэх талаар журамд тодорхой өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

Зарим сумууд ОНХС-ийн хөрөнгийг сум, орон нутгийг хөгжүүлэх зорилгоор томоохон үр дүнтэй төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байгаа боловч олонх сумууд ОНХС-ийн хөрөнгийг хэт жижиглэж хуваарилж байгаа нь сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, үр дүнгүй болгож байна.

Үнэлгээний хороог захиалагч болох аймаг, сумын Засаг даргын захирамжаар байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-нд заасны дагуу байгуулахгүй, ажлын алба болон хамаарал бүхий этгээдүүдийг томилж байгаа тул энэ заалтыг өөрчлөх шаардлагатай байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмрээ оруулж, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгодоо хүрсэн, үр ашигтай зарцуулсан сайн туршлагаас дурдвал:

Дэлүүн сум аймгийн ОНХС-ийн оролцоотойгоор сумын ОНХС-ийн хөрөнгөөр сумын ЗДТГ-ын барилгыг шинээр барьж, Сагсай сумын Соёлын төв үзэгчдийн суудалтай болсон байна.




Дэлүүн сумын ЗДТГ-ын байр



Сагсай сумын Соёлын төвийн
үзэгчдийн суудал

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Өлгий сумын 4, 9 дүгээр багт хэрэгжиж байгаа цэцэрлэгүүд, аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажлууд, аймгийн төв талбайд баригдсан Монгол Улсын баатар М.Икейн хөшөө зэрэг төсөл, арга хэмжээнүүд байна. Мөн зарим сумд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн гэрэлтүүлэг, трактор нийлүүлэх, стадионы засвар зэрэг ажлууд байна.



Икей баатарын хөшөө



Толбо сумын гэрэлтүүлэг

САНАЛ АСУУЛГЫН ТАЛААР.

1. Тус Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны талаарх авах санал асуулгад аймгийн төв болон 12 сум, нэг тосгоныг хамруулж санал асуулга авахад нийтдээ 665 иргэн оролцсон ба санал асуулгад оролцсон иргэдийн дундаж нас 40 байна.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн талаар хэр мэдээлэлтэй вэ? гэсэн асуултад 283 иргэн буюу санал асуулгад оролцсон иргэдийн 42.6 хувь нь “хангалттай”, 382 иргэн буюу 57.4 хувь нь “хангалтгүй” гэж хариулсан нь ОНХСангийн талаар иргэдийг мэдээллээр хангах ажил хангалтгүй байгааг харуулж байна.

3. Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх мэдээллийг хаанаас авсан бэ? гэсэн асуултад 24.2 хувь буюу 161 иргэн Засаг дарга, хороодын хэсгийн ахлагчаас, 31.0 хувь буюу 206 иргэн орон нутгийн мэдээллийн самбар, радио, телевизээс, 4.1 хувь буюу 27 иргэн Иргэний танхимын ажилтнаас, 40.8 хувь буюу 271 иргэн нутгийн иргэдээс гэсэн хариулт өгчээ. Энэ нь тухайн баг, хорооны зүгээс иргэдэд ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар мэдээлж, сурталчлах ажил хангалтгүй байгаатай холбоотой байна.

4. Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх холбогдох хууль тогтоомж, журам зааврыг судалж үзсэн үү? гэсэн асуулгад санал асуултад оролцсон иргэдийн 30.2 хувь буюу 201 иргэн “тийм”, 69.8 хувь буюу 464 иргэн “үгүй” гэж хариулсан байна. Санал асуулга өгсөн иргэд ОНХСангийн холбогдох хууль тогтоомж, зааврыг судалж үзээгүй байгаа нь иргэд, олон нийтэд ОНХС-ийн талаарх хууль тогтоомжийг сурталчилж, таниулах ажил хангалтгүй байгаатай холбоотой байна.

5. Таны баг, хорооны Засаг дарга 2019 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хамгийн түрүүнд хийх шаардлагатай ажлуудын саналыг иргэдээс авах ажлыг зохион байгуулсан үү? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 34.0 хувь буюу 226 иргэн “тийм”, 40.8 хувь буюу 271 иргэн “үгүй”, 25.3 хувь буюу 168 иргэн “сайн мэдэхгүй” гэж хариулсан байна. ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг иргэдэд танилцуулж, санал авах ажил хангалтгүй, иргэдийн оролцоог хангаагүй байна гэж үзэх үндэстэй байна.

6. “Та энэ үйл ажиллагаанд оролцож саналаа өгсөн үү?” гэсэн асуулгад санал асуултад оролцсон иргэдийн 33.2 хувь буюу 221 иргэн “тийм”, 66.8 хувь буюу 444 иргэн “үгүй” гэж хариулсан байна. Энэ нь иргэдийн оролцоо хангагдаагүй, мэдээлэл хүргэж, санал авах ажилд оролцуулах ажил хангалтгүй байгааг харуулж байна.

7. “Засаг дарга ийнхүү авсан саналыг эрэмбэлж, хамгийн их санал авсан ажлуудыг иргэдэд танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг хийсэн үү?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 25.9 хувь буюу 172 иргэн “тийм”, 47.4 хувь буюу 315 иргэн “үгүй”, 26.8 хувь буюу 178 иргэн “сайн мэдэхгүй” гэж хариулсан байна. Энэ нь иргэдээс санал асуулга аваагүй, нээлттэй хэлэлцүүлэг хийх талаар мэдээлэл хүргэж ажиллаагүйтэй холбоотой байна.

8. “Та нээлттэй хэлэлцүүлэгт оролцсон үү?” гэсэн асуулгад санал асуултад оролцсон иргэдийн 23.5 хувь буюу 156 иргэн “тийм”, 76.5 хувь буюу 509 иргэн “үгүй” гэж хариулсан байна. Энэ нь иргэдийн нээлттэй хэлэлцүүлэгт оролцох оролцоо тааруу байгааг харуулж байна.

9. “Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд бодитой хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавьдаг үү?” гэсэн асуултад 26.5 хувь нь буюу 176 иргэн “тийм”, 73.5 хувь нь буюу 489 иргэн “үгүй” гэж хариулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1-д заасан иргэдийн хяналт хангалтгүй хэрэгжиж байгааг харуулж байна.

10. “Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудад хэр сэтгэл хангалуун байдаг вэ?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 26.8 хувь буюу 178 иргэн “хангалттай сайн”, 42.7 хувь буюу 284 иргэн “хангалтгүй”, 30.5 хувь буюу 203 иргэн “мэдэхгүй байна” гэж хариулсан байна. Олонх нь буюу 73.2 хувь нь “хангалтгүй”, “мэдэхгүй байна” гэж хариулсан нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр талаарх ойлголт дутмаг, хийгдэж буй төсөл арга хэмжээ олон нийтэд хүртээмжгүй, сэтгэл хангалуун биш байгааг харуулж байна.

Холбогдох байгууллагын санал:


**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 7042-3264
2020. 11. 12 № 8-03/449
танай _____ -ны № _____ - Т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус аймагт 2019 оны орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд танай байгууллагаас хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцав.

Хийгдсэн аудитын тайлантай холбоотой ямар нэгэн санал үгүй болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



З.БОЛАТ



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 7042-3264

2020. 11. 12 № 5-03/750.
танай _____-ны № _____ - т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус аймагт 2019 оны орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд танай байгууллагаас хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцав.

Хийгдсэн аудитын тайлантай холбоотой ямар нэгэн санал үгүй болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Х.ЕРБОЛ

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.

1.2. Аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.

1.2.1 Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг холбогдох журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөсөн байна.

1.2.2. Аймаг, сумдын ОНХС-ийн нийт эх үүсвэрийн 95.4 хувийг ОНХС-гийн орлогын шилжүүлгээр бүрдүүлсэн байна.

1.2.3. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХСанд олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль журмыг баримталж хуваарилсан байна.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭГ ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.

2.1. Аймгийн дүнгээр 2019 онд иргэдийн саналаар дэмжигдээгүй 2476.9 сая төгрөгийн 135 төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

2.1.1. Ихэнх сумууд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу төлөвлөөгүй байна.

2.1.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээ орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан боловч холбогдох журам, зааврын дагуу төлөвлөгдөөгүй байна.

2.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллаагүй байна.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

2.2.2. Аймаг, сумын ОНХС-гаас нийтдээ 131.4 сая төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЖ, ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.

3.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, Иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллаагүй байна.

3.1.2. Аймаг, сумын захиргааны байгууллагууд ОНХС-ийн хэрэгжилт, үр дүнд хийх хяналт, шинжилгээ үнэлгээг холбогдох журмын дагуу хийж гүйцэтгээгүй байна.

3.2. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар журмын дагуу тайлагнаж, хүргүүлж ажилласан байна.

3.2.1. ОНХСангийн төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийн тайланг Төсвийн тухай хууль болон журам, зааварт тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлж ажилласан байна.

3.2.2 Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлсэн боловч тайлант онд алдаа, зөрчлийг давтан гаргасан байна.

3.2.3. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа нь орон нутгийн хөгжлийг дэмжихэд зохих үр дүнгээ өгч байгаа боловч орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим хууль журамд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I. Аймгийн ИТХ-ын дарга Н.Бейбитхан-д:

1.Орон нутгийн төсвийг ИТХ-аар хэлэлцэхдээ аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нэг бүрээр хэлэлцэж, иргэд, олон нийтийн саналаар дэмжигдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төсөвт тусгаж батлуулахгүй байх.

2.Хувийн хэвшлийн байгууллагад болон чиг үүрэгт хамааралгүй улсын төсвийн байгууллагуудад зориулж ОНХС-ийн төлөвлөгөөнд хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг тусгаж батлуулахгүй байх арга хэмжээ авч ажиллах.

II. Аймгийн Засаг дарга Д.Бауыржан-д:

1.Тендерийн үнэлгээний хороог байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна” гэсэн заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаж, аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх.

2.Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шинээр барилга барих ажлуудыг тухайн ондоо багтаан хэрэгжүүлэх, он дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулахгүй байх талаар анхаарч ажиллах.

3. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтыг сайжруулах, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын ажлын хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч, үр дүнг тооцож ажиллах.

4. Чанаргүй хийгдсэн ажил, дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээг хүлээж авсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн ажлын хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах.

III. Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Назым-д:

1. Төсвийн хөрөнгөөр худалдаж авах бараа, ажил, үйлчилгээний тендерийн баримт бичиг боловсруулахад компаниудын тендерт оролцох боломжийг хаасан шударга бус болзол шаардлага тавихгүй байх, тендерт оролцогч компаниудыг аль болох өрсөлдөх тэгш боломжоор хангасан тендерийн баримт бичиг боловсруулахад мэргэжлийн байгууллагын хувьд арга зүйгээр хангаж, ТБОНӨХБАҮХАТХ-ийг мөрдөж ажиллах, үнэлгээний хорооны гишүүдийн шийдвэрт хяналт тавьж, үнэлгээний хорооны гишүүдийн тендерийн бичиг баримтыг боловсруулах, үнэлгээ хийх чадварыг дээшлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах.

IV. Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга М.Тауке-д:

1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, тайлагнал, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг зохих журмын дагуу хийж, үр дүнг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудсаар мэдээлж байх.

V. Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Р.Хуатхан-д:

1. Сангийн сайдын 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4-т “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавих” гэсэн заалтын дагуу аймаг, сумын ОНХСангийн үйл ажиллагаанд жил бүр хяналт шалгалт хийж, чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах.

ХАВСРАЛТУУД:

ХАВСРАЛТ 1:

Баян-Өлгий аймгийн ОНХС-ийн 2019 оны эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	ОНХНС болон улсын төсвөөс				Орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр								Нийт эх үүсвэр	
		ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг /ТТХ-ийн 60.2.6, 60.2.7 орсон/		"Тогтвортой амжиргаа-3" төсөл /ТТХ-ийн 59.1.3/		ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	ТТХ-ийн 60.2.4 Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр		ТТХ-ийн 60.2.5, ЗГ-ын 2017 оны 230-р тогтоолын 2.2.4, тухайн ОНХ-ийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив тусламж, ОУБ-ийн төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг /ТТХ-ийн 59.1.3 хамаарахгүй зөвхөн тухайн орон нутагт /		Бусад орлого				
		төлөв	гүйц	Урамшуулал	Дэмжлэг		төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	
1	Аймгийн ОНХС	4168.69	4101.3			87.2							4255.9	4188.5	
2	Алтай сумын ОНХС	105.54	89.4	31.5	41.1	15.5							193.6	177.5	
3	Алтанцөгц сумын ОНХС	70.6	70.6		20.1								90.7	90.7	
4	Баяннуур сумын ОНХС	120.5	120.5		41.6								162.1	162.1	
5	Бугат сумын ОНХС	53.1	53.1		20.4								73.5	73.5	
6	Булган сумын ОНХС	232.3	232.3		85.9	24.2							342.4	342.4	
7	Буянт сумын ОНХСан	72.0	72		22.9	29.3							124.2	124.2	
8	Дэлүүн сумын ОНХС	224.6	224.6	63.3	83.8	55.0	45.0	45.0					471.7	471.7	
9	Ногооннуур сумын ОНХС	151.7	155.9		73.3								225.0	229.2	
10	Сарсай сумын ОНХС	102.7	102.7		33.7								136.4	136.4	
11	Толбо сумын ОНХС	92.73	92.73		35.0								127.7	127.7	
12	Улаанхус сумын ОНХС	170.3	170.3		63.5								233.8	233.8	
13	Цэнгэл сумын ОНХС	230.4	230.4		78.3								308.7	308.7	
	Өлгий сумын ОНХС	248.6	248.6		96.8	65.0							410.4	410.4	
14	Цагааннуур тосгоны ОНХС	81.3	81.3		0.0	1.8							83.1	83.1	
	Аймгийн нийт дүн	6,125.1	6,045.7	94.8	696.4	278.0	45.0	45.0	-	-	-	-	7,239.2	7,159.9	

ХАВСРАЛТ 2:

Баян-Өлгий аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хийгдсэн ажлын сонгон шалгаруулалт																
													/сая.төг/			
№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Төлөвлөсөн ажил				Нээлттэй тендер шалгаруулалт		Худалдан авах ажиллагааны онцгой журам						Бусад		
		Өмнөх оноос шилжсэн		Шинэ оны ажил				Хязгаарлагдмал ТШ		ХА		ШГБ				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	
1	Аймгийн ОНХС	17	1719.1	67	2536.8	11	1,303.0			29	907.8	23	225.9			
2	Алтай сумын ОНХСан			19	193.6					5	80.8	13	107.8			
3	Алтанцөгц сумын ОНХС			10	90.7				-	1	39.0	8	46.7			
4	Баяннуур сумын ОНХС			23	162.1	1	29.0		-	1	10.0	21	118.6			
5	Бугат сумын ОНХС			11	73.5							11	80.5			
6	Булган сумын ОНХСан			26	342.4	1	199.8					25	137.6			
7	Буянт сумын ОНХСан	3	81.9	8	42.3					1	19.9	6	17.4			
8	Дэлүүн сумын ОНХС	5	135	10	336.7	2	251.0		-	1	30.0	6	50.7			
9	Ногооннуур сумын ОНХС			30	225.0		-		-	1	30.0	28	190.0			
10	Сагсай сумын ОНХС	4	7.9	19	128.5		-		-	1	17.9	16	107.0			
11	Толбо сумын ОНХС	1	30	12	97.7		-		-	1	25.1	11	94.1			
12	Улаанхус сумын ОНХС	5	126.3	23	107.5				-	1	16.0	21	86.5			
13	Цагааннуур тосгоны ОНХСан			8	83.1					2	56.2	5	21.9			
14	Цэнгэл сумын ОНХСан	2	63.0	29	245.7					5	88.0	23	152.7			
15	Өлгий сумын ОНХСан	9	33.4	36	377.0					3	81.5	32	290.5			
	Аймгийн нийт дүн	46	2196.6	331	5042.63	15	1782.78	0	0	52	1402.2	249	1727.9	0	0	

ХАВСРАЛТ 3:

Баян-Өлгий аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ

/сая.төг/

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	ИТХ-аар батлагдсан ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ		Гэрээ байгуулсан ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ		Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ						Дутуу хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ			Огт хэрэгжээгүй ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	
		тоо	дүн	тоо	Гэрээний дүн сая/төг	тоо	Гэрээний дүн	Үүнээс дутуу олгосон санхүүжилт		Сангийн зорилгод нийцсэн үр дүнтэй болсон		тоо	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	тоо	дүн
								тоо	дүн	тоо	дүн					
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
1	Аймгийн ОНХС	84	4255.9	77	3986.2	75	3939.8	12	22.9	67	3933.8	2	46.5	33.4	2	27.5
2	Алтай сумын ОНХСан	19	193.6	18	188.6	18	188.6			18	188.6					
3	Алтанцөгц сумын ОНХС	10	90.7	7	66.3	7	66.3	1	1.8	6	63.3				3	18.7
4	Баяннуур сумын ОНХС	23	162.1	21	147.6	17	103.5	4	5.5	1	8.0	2	42.0	16.8	1	2.0
5	Бугат сумын ОНХС	11	73.5	11	80.5	7	54.5	2	3.0			2	8.0	4.5	3	18.0
6	Булган сумын ОНХСан	26	342.4	26	337.4	26	301.9	4	35.5	26	337.4					
7	Буянт сумын ОНХСан	11	124.2	10	119.2	10	113.5	6	5.7							
8	Дэлүүн сумын ОНХС	15	471.7	14	466.7	13	456.7	1	4.0	2	119.4				1	10.0
9	Ногооннуур сумын ОНХС	30	225.0	28	204.3	15	96.7	1	1.7			9	79.0	48.6	6	49.3
10	Сагсай сумын ОНХС	23	136.4	21	121.5	21	121.5	8	6.9	16	73.1	0.0	0.0	0.0	0.0	0.0
11	Толбо сумын ОНХС	13	127.7	12	119.2	12	119.2			12	119.2					
12	Улаанхус сумын ОНХС	28	233.8	27	228.8	23	210.3	11	16.5	3	116.8	3	15.0	14.5	1	3.5
13	Цагааннуур тосгоны ОНХСан	8	83.1	7	76.2	7	76.2			7	76.2					
14	Цэнгэл сумын ОНХСан	31	308.7	30	303.6	30	303.6	5	12.1							
15	Өлгий сумын ОНХСан	45	410.4	44	405.4	44	405.4			44	405.4					
	Аймгийн нийт дүн	377	7239.2	353	6851.5	325	6557.65	55	115.6	202	5441.21	18	190.5	117.8	17	128.99

ХАВСРАЛТ 4:

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Нийт илэрсэн зөрчлийн дүн /сая.төг/	Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, акт	Зөрчлийн ангилал																							
				Зориулалт бусаар зарцуулсан		Иргэдийн санааар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж, санхүүжүүлсэн		Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн		Дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтэрсэн		Бүртгэл тайланд тусгаагүй		ТЗЗҮ, зураг төсөв нь батлаг-даагүй		Төсөвт өртөгөөс илүү санхүү-жүүлсэн		Орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдаагүй		Хэрэгжээгүй, санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй		Захиалаг -чийн хяналт тавиагүй		Бусад			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн ОНХС	2,732.8	Акт	3	7.4													1	0.90			1	5.55			1	1.0
			Албан шаардлага	3	2,725.4	4	54.8	50	1,687.5	81		7	76.95	16	757.1					9	149.1						
			Зөвлөмж	9	-			1		2		1												2			3
2	Алтай сум	17.3	Акт																								
			Албан шаардлага	1	17.3									2	17.3												
			Зөвлөмж																								
3	Алтанцөгц сум	56.4	Акт	-	-																						
			Албан шаардлага	1	56.4	2	1.00									3	55										
			Зөвлөмж	-	-																						
4	Баяннуур сум	394.1	Акт	-	-																						
			Албан шаардлага	1	394.1	1	5.00	7	131.9					4	50	6	152							4	55.0		
			Зөвлөмж	-	-																						
5	Бугат сум	203.8	Акт	-	-																						
			Албан шаардлага	1	203.8	3	10.50	11	65.5					1	10	9	51							15	66.8		
			Зөвлөмж	-	-																						
6	Булган сум	31.4	Акт																								
			Албан шаардлага	1	31.4									6	31												
			Зөвлөмж																								
7	Буянт сум	10.9	Акт																								
			Албан шаардлага	1	10.9									3	11												
			Зөвлөмж																								
8	Дэлүүн сум	871.3	Акт	-	-																						
			Албан шаардлага	1	871.3	1	5.80	1	30.0					1	309	6	368							5	159.0		
			Зөвлөмж	-	-																						
9	Ногооннуур сум	446.3	Акт	-	-																						
			Албан шаардлага	1	446.3	7	38.90	25	196.6					5	38	14	122							7	50.0		
			Зөвлөмж	-	-																						
10	Сагсай сумын ОНХСан	78.2	Акт	1	0.3	1	0.27											1	0.02								
			Албан шаардлага	1	77.9			5	32.4	2	27.60											1	17.90			1	
			Зөвлөмж																								
11	Толбо сумын ОНХСан	47.0	Акт	-	-																						
			Албан шаардлага	1	47.0			6	35.5					1	1.5	2	10.0										
			Зөвлөмж	-	-																						
12	Улаанхус сум	138.5	Акт	-	-																						
			Албан шаардлага	1	138.5	11	15.20	6	31.3					9	61	3	20							2	11.0		
			Зөвлөмж	-	-																						
13	Цагааннуур тосгон	73.2	Акт																								
			Албан шаардлага	1	73.2			5	73.2																		
			Зөвлөмж																								
14	Цэнгэл сум	17.0	Акт																								
			Албан шаардлага	1	17.0			3	17.0																		
			Зөвлөмж																								
15	Өлгий сум	176.0	Акт																								
			Албан шаардлага	1.0	176.0			15	176.0																		
			Зөвлөмж																								
Аймгийн дүн			Акт	4	7.68	1	0	-	-	-	-	-	-	-	-	-	2	1	-	-	1	6	-	-	1	1	
			Албан шаардлага	17	5,286.5	29	131	134	2,477	83	28	7	77	48	1,286	43	779	-	-	10	167	-	-	34	342	-	-
			Зөвлөмж	9	-	-	-	1	-	2	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	2	-	3	-	
Аймгийн нийт дүн	5,294.2			5,294.2	30	131.4	135	2,476.9	85	27.6	8	77.0	48	1,285.9	43	779.2	2	0.9	10	167.0	1	5.5	36	341.8	4	1	

ХАВСРАЛТ 5:

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Акт			Албан шаардлага			Зөвлөмж /тоогоор/		
		Мөнгөн дүн	Мөнгөн дүнгийн биелэлт	Хэрэгжил тийн хувь	Мөнгөн дүн	Мөнгөн дүнгийн биелэлт	Хэрэгжил тийн хувь	Тоо	Тоо	Хэрэгжил тийн хувь
1	Аймгийн ОНХС	14509.1	14509.1	100%	517,300.0	517,300.0	100%	2	2	100%
2	Алтанцөгц сумын ОНХС	3000	3000	100%	12,000.0	12,000.0	100%			
3	Баяннуур сумын ОНХС	2500	2500	100%	91,300.0	91,300.0	0%			
4	Бугат сумын ОНХС	800	800	100%	176,800.0	88,400.0	50%			
5	Булган сум				89,600.0	89,600.0	100%			
6	Бүянт сум				94,300.0	94,300.0	100%			
7	Дэлүүн сумын ОНХС				66,800.0	66,800.0	100%			
8	Ногооннуур сумын ОНХС				160,100.0	46,800.0	29%			
9	Сагсай сум				40,700.0	40,700.0	0%			
10	Толбо сум				18,500.0	18,500.0	81%			
11	Улаанхус сумын ОНХС				243,500.0	86,200.0	35%			
12	Цэнгэл сум				84300	67300	80%			
13	Өлгий сум	1114.2	1114.2	100%	138700	61000	44%			
	Нийт дүн	21923.3	21923.3		1733900.0	1280200.0		2	2	1.0

Хавсралт 7.

Баян-Өлгий аймгийн сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн чиг үүргүүд																									
№	Сумын нэр	ТТХ-ийн 58.4.1. Сумын удирдлагыг хэрэгжүүлэх		ТТХ-ийн 58.4.2. сумын Засаг даргын шийдвэрээр отгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах;		ТТХ-ийн 58.4.3. сумын нутаг дэвсгэрийн дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэллүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг хийх;		ТТХ-ийн 58.4.4. мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;		ТТХ-ийн 58.4.5. сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх;		ТТХ-ийн 58.4.6. сумын нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах;		ТТХ-ийн 58.4.7. сумын доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, аричлгааг хийх, зохион байгуулах;		ТТХ-ийн 58.4.8. сумын тохижилт, мод, ургамал цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах арилгах;		ТТХ-ийн 58.4.9. усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх;		ТТХ-ийн 58.4.10. орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх;		ТТХ-ийн 58.4.11. хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.			
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24		
1	Атай сум					1	33.6		1	2.5		1	2.0			1	4.0			15	146.1	3	26.8		
2	Апанц сум											10	20			1	2.1	2	22.2	2	4.6	5	53.1		
3	Баяннуур сум					3	61.0				1	10.0	4	24.0		2	4.5	2	8.4			2	22.5		
4	Бугат сум															1	199.8			20.0	88.1	2	10.0		
5	Булган сум							1	2.5	2	9.2									10.0	50.8	1	5.0		
6	Буянт сум																			6	407.0	4	33.5		
7	Дэлүүн сум					3	15.6							1	4.0	1	11.0			15	77.6	12	66.2		
8	Ногооннуур сум	1	0.8			1	15.0	1	5.0											4	34.34	5	17.6		
9	Сагсай сум	1	5.0			7	53.8	2	9.6			1	2.0			1	4.0	2	10.0	3	44.97	5	56.5		
10	Толбо сум	1	5.0			1	6.7			1	2.0			1	4.0	1	5.0			16	173.58	2	35.4		
11	Улаанхус сум									7	18.5	3	5.2												
12	Цагааннуур тосгон					1	34.9													6	43.2	1	5		
5	Цэнгэл сум					1	5.1	5	98.0											24	190.2	1	5		
6	Өлгий сум					13	136.9									3	67.6			29	140.9				
Аймгийн нийт дүн		3	10.84	0	0	31	362.6	10	117.55	11	39.7	19	53.2	2	8	11	298	6	40.6	151	1411.39	49	357.9		

ХАВСРАЛТ 8:

**Баян-Өлгий аймгийн 2019 онд ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл,
арга хэмжээний талаар иргэдээс авсан санал, асуулга**

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Нийт санал өгсөн иргэдийн тоо	Санал авсан хэлбэр			Нийт саналын тоо /ажлаар/	Үүнээс	
			Цахим	Хурал уулзалт	Цаасаар		Батлагдсан саналын тоо /ажлаар/	Цуцлагдсан саналын тоо /ажлаар/
1	2	3	4	5	6	7	8	9
1	Аймгийн ОНХС	2942			2942	57	16	41
2	Алтай сум	7802	0	3901	3901	19	19	
3	Алтанцөгц сум	495		243	252	14	10	4
4	Баяннуур сум	931		451	480	24	14	10
5	Бугат сум	0	0	0	0	0	0	0
6	Булган сум	8318	0	4159	4159	27	26	1
7	Буянт сум	1844	0	922	922	8	8	0
8	Дэлүүн сум	1159		536	623	16	12	4
9	Ногооннуур сум	0	0	0	0	0	0	0
10	Сагсай сум	0	0	0	0	0	0	0
11	Толбо сум	284			284	13	5	8
12	Улаанхус сум	1289		660	629	62	21	41
13	Цагааннуур тосгон	178	0	89	89	7	7	0.0
14	Цэнгэл сум	128	0	64	64	31	31	0.0
15	Өлгий сум	1664	0	832	832	56	46	10
	Аймгийн нийт дүн	27034	0	11857	15177	334	215	119

Хавсралт 9

Сэдэв: Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа				
Тайлбар: Санал асуулганд 12 сум, 1 тосгон, аймгийн ОНХС нийтдээ 665 хүн оролцов				
№	Санал асуулга	Үзүүлэлт	Дүн	Эзлэх хувь
0	Хүний тоо /тухайн орон нутгийн/	Нийт хүн амын тоо		
		Судалгаанд оролцсон хүний тоо	665	100.0
1	Нас /дундаж/		40	100
2	Орон нутгийн хөгжлийн сангийн талаар хэр мэдээлэлтэй вэ?	Хангалттай	283	42.6
		Хангалтгүй	382	57.4
3	Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх мэдээллийг хаанаас авсан бэ?	а	161	24.2
		б	206	31.0
		в	27	4.1
		г	271	40.8
4	Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх холбогдох хууль тогтоомж, журам зааврыг судалж үзсэн уу?	Тийм	201	30.2
		Үгүй	464	69.8
5	Таны баг, хорооны Засаг дарга 2019 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хамгийн түрүүнд хийх шаардлагатай ажлуудын саналыг иргэдээс авах ажлыг зохион байгуулсан уу?	Тийм	226	34.0
		Үгүй	271	40.8
		Сайн мэдэхгүй байна	168	25.3
6	Та энэ үйл ажиллагаанд оролцож саналаа өгсөн үү?	Тийм	221	33.2
		Үгүй	444	66.8
7	Засаг дарга ийнхүү авсан саналыг эрэмбэлж, хамгийн их санал авсан ажлуудыг иргэдэд танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг хийсэн үү?	Тийм	172	25.9
		Үгүй	315	47.4
		Сайн мэдэхгүй байна	178	26.8
8	Та нээлттэй хэлэлцүүлэгт оролцсон уу?	Тийм	156	23.5
		Үгүй	509	76.5
9	Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд бодитой хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавьдаг уу?	Тийм	176	26.5
		Үгүй	489	73.5
10	Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудад хэр сэтгэл хангалуун байдаг вэ?	Хангалттай сайн	178	26.8
		Хангалтгүй	284	42.7
		Мэдэхгүй байна	203	30.5
11	Бодитой, үр дүнтэй гэж үнэлэгдсэн нийт 3 хүртлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг эрэмбэлж тайланд тусгах			
12	Ач холбогдолтой саналыг тайланд тусгах			

ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН :

АХЛАХ АУДИТОР

Д.НАЗГҮЛ

АУДИТОР

У.ЕРБОЛ

АУДИТОР

Х.ЕРКЕБУЛАН



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/92

Өлгий

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан "Нийцлийн аудитын түр журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2, 2016 оны А/95 тушаалаар баталсан "Акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын хавсралтын долоо дахь хэсгийн 7.1 дэх заалт, 2018 оны А/207 дугаар "Эрх үүрэг шилжүүлэх" тушаалын 5 дугаар хавсралтын 2.1, 2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны зарцуулалт" сэдвээр хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар болон Аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын мөрөөр тодорхой арга хэмжээ авч биелэлтийг 2021 оны 10 дугаар сарын 01-ны дотор ирүүлэхийг Аймгийн Засаг дарга Д.Бауыржан, Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Назым, Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Р.Хуатхан, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга М.Тауке нарт зөвлөсүгэй.

4. Аудитын зөвлөмж, акт, албан шаардлагыг статистик мэдээний бүртгэлд авч, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор Д.Назгүл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер Х.Женисбект даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН



Баян-Өлгий аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга бөгөөд
тэргүүлэх аудиторын 2020 оны
11 дүгээр сарын 12-ны өдрийн
А/20 тоот тушаалын хавсралт

8317144071
БЮА0074 9007245
/сая.төг/

№	Байгууллагын нэр	Төлбөрийн акт		Албан шаардлагын	
		Тоо	Мөнгөний дүн	Тоо	Мөнгөний дүн
1	Алтай сумын ОНХСан			1	17.3
2	Алтанцөгц сумын ОНХСан			1	56.4
3	Баяннуур сумын ОНХСан			1	394.1
4	Бугат сумын ОНХСан			1	203.8
5	Булган сумын ОНХСан			1	31.4
6	Буянт сумын ОНХСан			1	10.9
7	Дэлүүн сумын ОНХСан			1	871.3
8	Толбо сумын ОНХС			1	47.0
9	Ногооннуур сумын ОНХСан			1	446.3
10	Сагсай сумын ОНХС	1	0.3	1	77.9
11	Улаанхус сумын ОНХСан			1	138.5
12	Цагааннуур тосгоны ОНХСан			1	73.2
13	Цэнгэл сумын ОНХСан			1	17.0
14	Өлгий сумын ОНХСан			1	176.0
15	Аймгийн ОНХС	3	7.4	3	2725.4
	Нийт дүн	4	7.7	17	5286.5


**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2020.11.13 № 692
танай _____-ны № _____ - т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
С.ЭНХБААТАР ТАНАА**

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар хийсэн "Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны зарцуулалт" сэдэвт нийцлийн аудитын тайланг хавсралт судалгаануудын хамт хүргүүлэв.

Хавсралт хуудас.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



D:\bichig hereg\2020\hblank.doc